

ЗАСГИЙН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 10 ДУГААР САРЫН ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн салбарт:

Төрийн албан хаагчдын цалингийн түвшинг дээшлүүлж, дундаж цалинг 250,0 мянган төгрөгт хүргэх асуудлыг судалж, холбогдох тооцоо хийсний үндсэн дээр “Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, доод жишгийг шинэчлэн тогтоох тухай” Засгийн газрын тогтоолын төсөл боловсруулан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, 2007 оны 237 дугаар тогтоолоор батлуулав. Энэ удаа нийт албан хаагчдын цалинг ижил хувь хэмжээгээр нэмэгдүүлдэг аргаас татгалзаж, цалингийн урамшуулах үүргийг өндөржүүлэх, албан тушаалын үүрэг, хариуцлага ачааллыг харгалзан цалин хөлсийг ялгаатай нэмэгдүүлэх зарчим баримталсан болно.

Уг тогтоолоор төрийн удирдах болон гүйцэтгэх албан тушаалын зэрэглэл хоорондын цалингийн зөрүүг нэмэгдүүлж зохистой харьцаанд оруулах, улс төрийн болон удирдах албан тушаалтны албан үүргээ нэр төртэй хэрэгжүүлэх боломж нөхцөлийг сайжруулах зорилгоор төрийн өндөр албан тушаалтан болон түүнтэй адилтгах албан тушаалтны цалинг 75 хувиар, улс төрийн албан тушаалтан, шүүх, прокурорын ажилтнуудын албан тушаалын цалинг 2,0 дахин нэмэгдүүлэв. Төрийн албан хаагчдын нэмэгдэл хөлсний системийг үе шаттайгаар боловсронгуй болгох алхам хийж төрийн захиргааны албан тушаалын албан ажлын онцгой нөхцөлийн нэмэгдлийг хасч үндсэн цалинд нь шингээх, улс төрийн албан тушаалын ажил үүргийн онцлогийг харгалзан албан ажлын онцгой нөхцөлийн нэмэгдлийг нь 30 хувь болгон нэмэгдүүлэхээр шийдвэрлэв. Харин төрд туршлагатай, мэргэжлийн өндөр ур чадвартай албан хаагчийн хэрэгцээ өнөө ч байгааг харгалзан төрийн захиргааны албан хаагчдын төрийн алба хаасан хугацааны болон зэрэг дэвийн нэмэгдэл, ажил үүргийн онцлогийг нь харгалзан төрийн тусгай албан хаагчдын бүх төрлийн нэмэгдлийг хэвээр үлдээв.

Түүнчлэн төрийн үйлчилгээний албан хаагчдын цалингийн сүлжээний доод жишгийг шинжлэх ухаан, мэргэжлийн боловсрол, бага, дунд боловсрол, эрүүл мэнд, соёл урлаг болон нийтлэг үйлчилгээний гэсэн 6 дэд сүлжээ, доод жишиг болгон өөрчлөлөө. Ингэхдээ боловсролын салбарын багш, ажилчдад 3 сайдын хамтарсан тушаалаар тогтоон олгож байсан нэмэгдэл хөлс, 2004 онд эрүүл мэндийн сайдаас өгсөн чиглэлийн дагуу бий болсон эрүүл мэндийн салбарын ажилтнуудын цалингийн өсөлтийг салбарын сүлжээний доод жишигт шингээн тооцов. Ингэснээр боловсрол, эрүүл мэндийн салбарт бий болсон цалингийн гажуудлыг арилгаж, гол мэргэжлийн албан хаагчдын цалин хөлсний түвшин ойролцоо тогтож байна.

Дээрх арга хэмжээг авснаар төрийн албан хаагчдын дундаж цалин 55,0 хувиар, хамгийн бага тушаалын албан хаагчдын цалин 40,0-50,0 хувиар нэмэгдэж байгаа бөгөөд 2007 оны сүүлийн улиралд **46,1** тэрбум төгрөг зарцуулах юм.

Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2007 оны 10 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн 30.4 хувиар өсгөж шинэчлэн тогтоохоор Засгийн газрын тогтоолын төсөл боловсруулж, Засгийн газрын 2007 оны 9 дүгээр сарын 27-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, Засгийн газрын 2007 оны 240 дүгээр тогтоолоор батлуулав. Уг

тогтоолоор хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг сард 90000 /ерэн мянган/ төгрөг буюу нэг цагт 535 төгрөг 71 мөнгө байхаар шинэчлэн тогтоож, мөрдүүлэв.

Засгийн газраас нийгмийн даатгалын сангаас олгох бүрэн тэтгэврийн доод хэмжээ болон хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2007 оны 10 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн нэмэгдүүлж шинэчлэн тогтоох болсонтой холбогдуулан нөхөн олговрын доод хэмжээг 2007 оны 10 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн 15750 төгрөг буюу 30.4 хувиар нэмэгдүүлэн 67500 төгрөг болгох асуудлыг судлан УИХ-ын тогтоолын төсөл боловсруулав. Тогтоолын төсөлд яамдын саналыг тусган Засгийн газрын 2007 оны 9 дүгээр сарын 27-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, УИХ-д өргөн бариад байна.

Монгол Улсын Засгийн газрын 2006 оны 160 дугаар тогтоолоор баталсан “Хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах, үр дүн биелэлтийг дүгнэх, мэдээлэх журам”-ын дагуу Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд гарсан хууль тогтоомж, Засгийн газрын тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийг 2007 оны гуравдугаар улирлын байдлаар гаргаж, дүнг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлэв. 2007 оны гуравдугаар улирлын байдлаар Улсын Их Хурлын тогтоол, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж, Засгийн газрын тогтоол, Ерөнхий сайдын захирамж, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл зэрэг 41 шийдвэрийн 55 заалтыг хяналтад авч, биелэлтийн явцын мэдээг яамны газар, хэлтэс, харьяа агентлаг, байгууллагуудаас авч нэгтгэн Засгийн газрын 2006 оны 51 дүгээр тогтоолд заасан журмын дагуу хяналт-шинжилгээ хийж, үнэлгээ өгөв. Хяналтад авагдсан тогтоол, шийдвэрийн нийт заалтын 36 буюу 65.4 хувь нь бүрэн буюу 100 хувь биелсэн, 19 буюу 34.5 хувь нь 30.0-90.0 хувийн хэрэгжилттэй байна. Ерөнхий биелэлтийн дүн 89.2 хувьтай байна. Үүнээс хууль тогтоомжийн биелэлт 83.3 хувь, Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилт 90.0 хувьтай байна.

Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн салбарын хэмжээнд 423.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийв. Нийслэлийн Баянзүрх, Баянгол, Сонгинохайрхан дүүргүүдэд 174.0 сая, Говьсүмбэр, Хэнтий, Баянхонгор, Дорнод, Увс аймгуудад 240.0 сая, яамны барилгын засварт 36.0 сая төгрөгийн санхүүжилт хийв. Барилга угсралт болон засварын ажлыг объектэн дээр нь очиж гүйцэтгэлийг шалгахад Төв аймгийн барилга угсралтын ажил 7 сард эхэлсэн, ажлын 20%-ийг гүйцэтгэсэн авах санхүүжилтийнхээ 80%-ийг авсан байгаа байдлыг орон нутгийн удирдлагуудад мэдэгдэж, тодорхой хугацаагаар хэрэгжүүлэх үүрэг өглөө. Говьсүмбэр аймгийн барилгын засварын ажлыг шалгахад ажил нь бүрэн дууссан гэрээнээс гадуур нэмэлт 10-аад сая төгрөгийн ажлыг хийж, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсийн ажилтнуудын нийгмийн асуудлыг шийдвэрлэн ажиллагсадыг орон сууцаар хангасан, ажлынхаа эцсийн гүйцэтгэлийг гаргаж өгөхөд бэлэн болсныг тухайн орон нутгийн удирдлагууд мэдэгдлээ. Баянзүрх дүүргийн барилга угсралтын ажил маш шуурхай явагдаж бөгөөд гэрээт хугацаандаа ажлаа гүйцэтгэх боломжтой гэж үзлээ.

Яамны төвлөрсөн арга хэмжээнээс энэ сард 14,3 сая төгрөг зарцуулснаас Хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах арга хэмжээнд 2,0 сая, Монголын ахмадын чөлөөт холбоонд 3,0 сая, Хүн ам зүйн нөөцөөс орон нутгийн нийгмийн ажилтанг мэргэшүүлэх сургалтын арга хэмжээнд 6,6 сая, Хөгжлийн бэрхшээлтэй эмзэг бүлгийн арга хэмжээнд 0,8 сая төгрөг тус тус зарцуулаад байна.

Тайлант хугацаанд Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсүүдэд бүртгүүлсэн ажил идэвхтэй хайж байгаа ажилгүй иргэдийн тоо 32.0 мянга, ажилгүйдлийн түвшин 3.1 хувь болж өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад ажилгүй иргэдийн тоо 3237 хүнээр буюу 9.2 пунктээр буурч, ажилгүйдлийн түвшин 0.4 пунктээр буурсан байна. Ажилгүйчүүдийн хөдөлгөөнийг 2007 оны эхний 9 сарын байдлаар авч үзвэл нийт 45119 ажилгүй иргэд шинээр бүртгүүлж, бүртгэлээс 45789 хасагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад шинээр бүртгүүлсэн ажилгүй иргэдийн тоо 2449 хүнээр, бүртгэлээс хасагдсан ажилгүй иргэдийн тоо 5356 хүнээр тус тус нэмэгдсэн байна. Тайлант хугацаанд ажил хайгчдад ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх үйлчилгээ үзүүлж нийт 60.6 мянган ажилгүй иргэдийг хамруулсан байна. 2007 оны эхний 9 сарын байдлаар нийт 38234 иргэнийг ажилд зуучлан оруулсан нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 7981 хүнээр буюу 26.4 пунктээр нэмэгдсэн байна. йлангийн хугацаанд ажил олгогчдоос нийт 46400 ажлын байрны захиалга ирүүлсэн байна. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад тайлант хугацаанд ажил олгогчдоос ирүүлсэн ажлын байрны захиалга 12161-ээр буюу 35.5 пунктээр нэмэгдсэн байна. Энэ хугацаанд нийт 68586 ажлын байр шинээр бий болсон байна. Шинээр бий болсон ажлын байрны 67.6 хувь нь байнгын, 32.4 хувь нь улирлын чанартай ажлууд байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд нийт 7819.4 сая төгрөгийн хөрөнгө төвлөрүүлсэн байна. Нийт төвлөрсөн хөрөнгийн 99.6 хувь буюу 7788.8 сая төгрөгийг гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авч байгаа байгууллагуудын ажлын байрны төлбөрөөс, 1.6 сая төгрөгийг жижиг зээлийн хүүгийн орлогоос, 29.0 сая төгрөгийг бусад эх үүсвэрээс бүрдүүлсэн байна. Тайлант хугацаанд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ, арга хэмжээнд давхардсан тоогоор 139712 иргэн хамрагдаж нийт 8360.9 сая төгрөгийг зарцуулсан байна. Ажилд зуучлахад нийт зарцуулсан хөрөнгийн 1.9 хувь буюу 156.1 сая төгрөгийг зарцуулж 38234, ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангахад нийт зарцуулсан хөрөнгийн 2.1 хувь буюу 176.5 сая төгрөгийг зарцуулж 60561, мэргэжил олгох давтан сургалтад хамруулахад нийт зарцуулсан хөрөнгийн 8.9 хувь буюу 745.5 сая төгрөгийг зарцуулж нийт 14927 иргэнийг тус тус хамруулсан байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээ. Үүнд, нийтийг хамарсан ажил зохион байгуулахад нийт зарцуулсан хөрөнгийн 6.9 хувь буюу 574.5 сая төгрөгийг зарцуулж 11001, ажил олгогчийг дэмжихэд нийт зарцуулсан хөрөнгийн 2.9 хувь буюу 243.0 сая төгрөгийг зарцуулж 829 иргэнийг хамруулсан байна. ХХҮХ-дийн материаллаг баазыг бэхжүүлэхэд нийт хөрөнгийн 3.0 хувь буюу 250.7 сая, ажилтнуудын мэдлэг, мэргэшлийг дээшлүүлэхэд нийт хөрөнгийн 0.4 хувь буюу 33.4 сая, хувиараа болон нөхөрлөл хоршооны хэлбэрээр хөдөлмөр эрхлэх иргэн аж ахуй нэгжид жижиг зээл олгох арга хэмжээнд нийт хөрөнгийн 62.3 хувь буюу 5208.2 сая, бизнес инкубаторын үйлчилгээнд нийт хөрөнгийн 4.8 хувь буюу 398.7 сая, төсөл хөтөлбөр боловсруулахад нийт хөрөнгийн 0.2 хувь буюу 12.9 сая, аж ахуй эрхлэх сургалтад нийт хөрөнгийн 2.1 хувь буюу 139.0 сая, ХЗЗ-ийн мэдээллийн тогтолцоог боловсронгуй болгох арга хэмжээнд нийт хөрөнгийн 1.7 хувь буюу 143.6 сая, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих шинэ үйлчилгээ, арга хэмжээг туршин нэвтрүүлэхэд нийт хөрөнгийн 1.7 хувь буюу 139.0 сая, хяналт шалгалтын зардалд 0.1 хувь буюу 11.5 сая, зээлийн хүүгийн нөхөн төлбөрт хөрөнгийн 1.1 хувь буюу 88.9 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Боловсролын салбарт:

Ерөнхий боловсролын сургуулийг 12 жилийн тогтолцоонд шилжүүлэх шилжилтийн графикийн 2 хувилбарыг Боловсролын хүрээлэн, аймгуудын Боловсрол, соёлын газруудтай дахин хэлэлцэж, шилжилтийг 2008-2009 оны хичээлийн жилээс эхлэн 5 жилд багтаан хийх нэгдсэн дүгнэлтэд хүрлээ. Шилжилтийн графикийн хувилбарын төслийн талаар аймаг нийслэлийн боловсролын байгууллагын удирдах ажилтан, багш нараас санал авахаар хүргүүлээд байна.

Япон улсын засгийн газраас хэрэгжүүлж буй JENESYS хөтөлбөрийн дагуу Япон улсын ерөнхий боловсролын сургуулиудын үйл ажиллагаатай танилцах, туршлага судлах монголын япон хэлний сургалттай сургуулиудын 10 дугаар ангийн 90 сурагч, 7 багшийг сонгон шалгаруулах ажлыг Япон улсын ЭСЯ, ГХЯ, Японы сайн дурын байгууллагуудтай хамтран гүйцэтгэлээ. Эдгээр багш сурагчид 11 дүгээр сарын 12-ноос Япон улсад 10 хоног аялах болно.

Хоёр улсын Засгийн газар хоорондын гэрээ, хэлэлцээр, хамтын ажиллагааны хөтөлбөрийг тус тус үндэслэн Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2007 оны 358 дугаар тушаалаар нийт 10 орны 153 оюутныг Монгол Улсын 4 их, дээд сургуульд 2007-2008 оны оны хичээлийн жилд Монгол Улсын Засгийн газрын тэтгэлгээр суралцуулахаар шийдвэрлэлээ.

Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2007 оны 369 дүгээр тушаалаар докторын сургалт эрхлэхэд баримтлах шинэ журам мөрдөгдөж эхэлсэнтэй холбогдуулан 8 их сургуулийг түшиглэсэн нийт 33 докторантурын хороог 14 чиглэлээр байгуулсан.

Түүх, соёлын үл хөдлөх дурсгалт зүйлийг хамгаалах, сэргээн засварлах үндэсний хөтөлбөрийн хүрээнд БНХАУ-ын Засгийн газрын буцалтгүй тусламжаар Богд хааны ордон музейн төв хаалга болон урд талын талбайг сэргээн засварлах ажлын хаалтын ёслол 10 дугаар сарын 8-нд боллоо. Уг хаалгыг сэргээн засварлахад тэрбум гаруй төгрөг зарцуулсан бөгөөд Богд хаант Монгол Улсын хаан 8 дугаар богд Жавзандамбын Ногоон ордон байсан түүхийн дурсгалт барилга, түүх соёлын хосгүй үнэт үзмэр хадгалагдаж байдаг манай соёлын өвийг оршин тогтнох хугацааг уртасгаж анхных нь төрхөөр хойч үедээ өвлүүлэн үлдээх боломжийг бүрдүүлсэн өндөр ач холбогдолтой арга хэмжээ боллоо.

“Соёл урлаг-хүний хөгжил” аяныг 10 дугаар сарын 5-ны өдрөөс эхлэн бүтэн сарын хугацаанд Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2007 оны 338 дугаар тушаалаар баталсан төлөвлөгөөний дагуу орон даяар зохион байгуулж байна. Аяны хүрээнд өнөөгийн соёлын үйлчилгээний чанар, хүртээмж, цаашид авах арга хэмжээг тодорхойлох зорилгоор “Соёлын үйлчилгээ-хүний хөгжилд” социологийн судалгааг уран бүтээлчид болон иргэдийн дунд явуулж байна. Уг аяны үндсэн гол ач холбогдол нь Соёлын мастер төлөвлөгөөг боловсруулахад чиглэгдэж байна. Энэ аяны хүрээнд соёл урлагийн салбарын 40 гаруй ажилтнууд баг болон нийслэл, орон нутаг ажиллаж байна.

Уртын дуучдын улсын 10 дахь удаагийн уралдааныг 2007 оны 17-19-ний өдрүүдэд Улсын филармонийн концертийн их танхимд зохион байгууллаа. Уралдаан мэргэжлийн дуучин, ардын авъяастан гэсэн хоёр ангиллаар тус бүр 2 үе шаттай болж,

хот хөдөөгийн нийт 80 гаруй уран бүтээлчид оролцож шилдгүүдээ шалгарууллаа. Энэ удаагийн уралдааны онцлог нь өмнөх уралдаануудаас илүү өргөн цар хүрээг хамарсан, оролцогчид эртний мартагдсан дуунуудаас сугалж дуулсан учир уран бүтээлчдийн ур чадварыг бүрнээ сорьсон илүү сонирхолтой, чанартай арга хэмжээ болж чадлаа.

“Угийн бичиг хөтлөх журам”-ын төслийг боловсруулан Засгийн газрын 257 дугаар тогтоолоор батлууллаа. Өмнөх журам нь хүн амыг овогтой болгох талаас нь түлхүү анхаарсан байсан бол энэ удаагийн журам нь угийн бичгийг хэрхэн хөтлөх, ямар нөхцөлд төрөл ойртох, холдох вэ зэрэг асуудлыг шинжлэх ухааны үндэслэлтэй цогцоор нь авч үзсэнээрээ давуу болсон. Мөн Монголын хүн амын дотор төрөл ойртолтын төвшин өсөхийн хэрээр удамшлын өвчин, согог, төрөлхийн оюун ухааны хомсдол, бие бялдрын дархлаа сул, зан ариншингийн өөрчлөлттэй үр удам төрөх явдал нэмэгдэж буй энэ цаг үед эрдэмтэд удам угсааны утга учрыг тайлсан шинжлэх ухааны үндэслэлтэй үлгэрчилсэн гарын авлага бэлтгэж байна. Уг гарын авлагыг иргэдэд төрөөс үнэ төлбөргүй тараах юм.

“Шинжлэх ухаан, технологийн тухай” хуулийн 8.1.11 заалтыг үндэслэн “Шинжлэх ухааны докторын зэрэг хамгаалуулах, олгох, журам”-ыг Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 365 дугаар тушаалаар батлан Шинжлэх ухааны докторын зэрэг хамгаалуулах зөвлөлүүдийг 2008 оны 1 дүгээр улиралд багтаан байгуулахыг докторын зэрэг хамгаалуулдаг Их, дээд сургуулиудын удирдлагуудад үүрэг өгөн ажиллаж байна.

Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2007 оны 361 дүгээр тушаалаар Япон улсын тусламжаар байгуулагдсан нанотехнологийн лабораторид ашиглах Атомын хүчний микроскопыг тээвэрлэх, гаалийн төлбөр төлөх, суурилуулахад 2007 онд 10 сая төгрөг, “Хүннү судлал” сэдэвт ажилд 2008 онд 7 сая төгрөг, “Шударга бус өрсөлдөөний эрх зүйн зохицуулалтын үнэлгээ” сэдэвт ажилд 2008 онд 3.5 сая төгрөгийг Шинжлэх ухаан, технологийн сангаас санхүүжүүлэхээр шийдвэрлэлээ.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам, Шинжлэх ухааны академиас хамтран “Соёлын өв санг хамгаалах тухай” эрдэм шинжилгээний хурал хийх бэлтгэл ажиллагааг хангах зорилгоор илтгэл, урилга, хурлаас гарах зөвлөмжийн төсөл боловсруулан Ерөнхийлөгчийн тамгын газарт хүргүүлээд байна.

2007 оны 10 дугаар сарын 14-нөөс 11 дүгээр сарын 2-ны өдрүүдэд Парис хотноо болж буй ЮНЕСКО-гийн 34 дүгээр бага чуулганд Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд оролцон “Боловсрол, соёл, шинжлэх ухааны салбарын өнөөгийн байдал, цаашдын чиг хандлага” сэдвээр илтгэл тавьсан. Мөн ЮНЕСКО-гийн Байнгын төлөөлөгчийн газрын дэргэдэх зөвлөлийн гишүүн орноор Монгол Улсыг сонгоход дэмжлэг авах зорилгоор 2 талт болон олон талт уулзалтуудад оролцсон бөгөөд ингэснээр Монгол Улс ЮНЕСКО-ийн Гүйцэтгэх зөвлөлийн сонгуульд амжилттай оролцож, Ази тивд нэр нөлөө бүхий орнуудтай эн зэрэгцэн өрсөлдөж, гишүүн орноор сонгогдсон явдал нь манай орны нэр хүнд олон улсын тавцанд өсөн бэхжихийн зэрэгцээ Монгол Улс ЮНЕСКО-гийн цаашдын хамтын ажиллагааны хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулах алхам боллоо.

Боловсрол, соёл, шинжлэх ухааны салбарын статистикийн мэдээллийг цуглуулах, хянах, нэгтгэн боловсруулах үйл ажиллагааг автоматжуулах зорилгоор Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам болон нийт аймаг, нийслэлийн Боловсрол, соёлын газруудад сервер суурилуулж тохиргоо хийж дууслаа. Ийнхүү орон нутагт Боловсрол, соёл, шинжлэх ухааны удирдлагын мэдээллийн системийг автоматжуулах техникийн нөхцөл бүрдэж байгаа нь анхан шатны нэгжид мэдээллийн технологид суурилсан мэдээллийн сан үүсч улмаар үндэсний хэмжээнд боловсролын салбарын удирдлагын мэдээллийн нэгдсэн сан бий болгох, статистикийн мэдээллийг үнэн бодитой хүлээн авах, түүний шуурхай байдал хангагдах зэрэг ач холбогдолтой юм.

Эрүүл мэндийн салбарт:

Хүн амын эрүүл мэндийг хамгаалах талаар авсан арга хэмжээ, үр дүнгийн үнэлгээ

“Эрүүл монгол хүн” үндэсний хөтөлбөрийг орон нутагт хэрэгжүүлэх багийн нэгдсэн сургалтыг аймаг, дүүрэг бүрээс холбогдох эмч, удирдах ажилтнуудаас бүрдсэн 8 хүний бүрэлдэхүүнтэй багт 7 чиглэлээр нийт 237 хүнийг хамруулан зохион байгуулав. Сургалтын гол зорилго нь хөтөлбөрийн үндсэн чиглэл, ерөнхий зарчмын талаар нэгдсэн ойлголттой болох, өвчнийг эрт илрүүлэх үзлэгийн аргачлал, удирдамжтай дэлгэрэнгүй танилцах, орон нутагт хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө боловсруулж гаргах, санал бодлоо солилцох байлаа.

Дархан-Уул аймгийн Хонгор сумын эмнэлэгт УАЗ-22069 маркийн автомашиныг Эрүүл мэндийн сайдын 2007 оны 256 тоот тушаалаар хуваарилан олгов.

Багц цаг биелүүлсэн (60), шалгаруулалтын болзол хангасан (19), мэргэжлийн үйл ажиллагаа явуулах шалгалтанд тэнцсэн (190), гадаадын (3) эмнэлгийн мэргэжилтнүүдэд Эрүүл мэндийн сайдын 2007 оны 250, 253, 259 тоот тушаалуудаар мэргэжлийн үйл ажиллагаа явуулах зөвшөөрлийн гэрчилгээ олгов.

ХОЁР. ШУУРХАЙ МЭДЭЭЛЭЛ

3.1. Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх талаар авах арга хэмжээнд хийсэн үнэлгээ

“Улаанбурхан өвчнөөс сэргийлье” уриан дор 2007 оны 10 сарын 1-нээс 10-ны өдрүүдэд зохиогдсон дархлаажуулалтын 10 хоногоор Нийслэлийн 2-10 насны хүүхдийг улаанбурханы вакцинаар нэмэлт дархлаажуулалтын арга хэмжээг зохион байгуулав.

“Нийслэл хотын 2-5 насны хүүхдийн дунд пневмококкт халдварын үүсгэгчийн бүтцийг тодорхойлох тандалт, судалгаа” төслийг Дэлхийн эрүүл мэндийн байгууллага, АНУ-ын Жон Хопкинсийн Их Сургуультай хамтран Халдварт өвчин судлалын үндэсний төвд хэрэгжүүлж эхлэв.

3.2. Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн үнэлгээ

Эрүүл мэндийн яаманд 2007 оны 09 дугаар сарын 22-ны байдлаар иргэдээс бичгээр 433 (98.7%), амаар 10 (1.3%) нийт 443 өргөдөл, гомдол, санал ирсэн байна.

Ирсэн өргөдөл, гомдлын 428 (96.6%) нь өргөдөл, 6 (1.3%) нь гомдол, 9 (2.1%) нь санал, мэдээлэл байгаагаас 423 (95.5%)-ыг хуулийн хугацаанд шийдвэрлэж, 20 (4.5%)-ийн шийдвэрлэх хугацаа болоогүй байна.

Өргөдөл, гомдлыг агуулгаар нь ангилж үзвэл:

1. Нийгмийн чиглэлээр (ажилд оруулахыг хүссэн, гадаадад эмчлүүлэхэд дэмжлэг үзүүлэхийг хүссэн, эмчилгээний төлбөрөөс чөлөөлж өгөхийг хүссэн, автомашин, тоног төхөөрөмж олгохыг хүссэн, эмнэлэгт хэвтэж эмчлүүлэхийг хүссэн, орон сууц хүссэн, захиргааны чөлөө хүссэн) 102 буюу 23.1%
2. Мөнгөн тусламж, эмчилгээний зардал, зээл хүссэн 36 буюу 8.1%
3. Сургалт, төсөлд хамрагдах, шагналын асуудлаар 39 буюу 8.8%
4. Бусад асуудлаар (Клиникийн нэгдсэн 2-р эмнэлгээр үйлчлүүлэхийг хүссэн, эрүүл ахуйн асуудлаар, виз гаргуулахад дэмжлэг хүссэн, эрүүлжүүлэх байрны талаархи хүсэлт гэх мэт) 266 буюу 60.0% тус тус эзэлж байна.

3.3. Тухайн сард хийсэн ажилд өгөх үнэлгээ

10 дугаар сард тус яамны үйл ажиллагаа хэвийн явагдлаа.

Боловсрол, соёл, шинжлэх ухааны сай, Эрүүл мэндийн сайд нарын хамтарсан 2006 оны 379/341 тоот тушаалаар батлагдсан “Ерөнхий боловсролын сургуулийн Үдийн цай хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд мөрдөр журам”-д “Үдийн цай” хөтөлбөрийн хэрэгжилтэнд хийсэн хяналт-шинжилгээний дүнг үндэслэн нэмэлт өөрчлөлт хийв.

Монгол улсын Ерөнхий сайдын 2007 оны 66 тоот захирамж болно Төрийн албан хаагчийн тоо бүртгэлийн улсын комиссын даргын 2007 оны 01 тоот тушаалын дагуу Төрийн албан хаагчийн тоо бүртгэлийн хийх тооллогын дэд хэсэг, салбар комиссыг байгуулж, бүртгэл хийх хуваарийг гаргав. Бүртгэлийг 2007 оны 11 сарын 23-ны дотор гаргаж Төрийн албаны зөвлөлд хүлээлгэн өгнө.

Монгол Улсын Засгийн газрын 2007 оны 190 тоот тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор “Нээлттэй хаалганы өдөр”-ийг 10 сарын 19, 20-ны өдрүүдэд зохион байгуулав.

3.4. Нэн шаардлагатай эмийн хангамжийн мэдээ

Энэ сарын байдлаар Монголэмимпекс ХК-ны агуулахад 166 нэрийн 536,0 сая төгрөгийн, орон нутгийн Эм хангамж компаниудын агуулахад 45-153 нэрийн 502,4 сая төгрөгийн үндэсний зайлшгүй шаардлагатай эм(ҮЗШЭ)-ийн үлдэгдэлтэй байна. ҮЗШЭмийн хангамж нэр төрлөөр Улаанбаатар хотод 60%, хөдөө орон нутагт 40,0-53,0%-тай байна.

Энэ сард ЭМЯ-ны зөвшөөрлийн дагуу Еврофарм ХХК, МЭИХК, Цахиур төмөр ХХК, Медимпекс ХХК, Тавин-Ус ХХК, Аниримпекс, Ган-Эм ХХК, Цомбо ХХК зэрэг эм ханган нийлүүлэх байгууллагууд импортын гэрээний дагуу ОХУ-ын БурятФармация, Мосхимфарм, Дальхимифарм, ХБНГУ-ын Карл Сторз, Энэтхэг улсын Himalaya drug болон Medopharm эмийн үйлдвэр, Солонгос улсын Medica Korea үйлдвэрээс импортын лиценцэд заагдсан эм, эмнэлгийн хэрэгслийг импортоллоо.

3.5. Эх, хүүхдийн эндэгдэл, цочмог халдварт өвчний өвчлөл, нас баралтын мэдээ, үнэлгээ

2007 оны эхний 9 сарын байдлаар улсын хэмжээнд нийт 40149 эх төрсөн нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 4408 тохиолдлоор нэмэгдсэн ба Говь-сүмбэр, Увс аймагт төрөлт буурч, бусад аймаг болон Улаанбаатар хотод нэмэгдсэн байна. Улсын хэмжээнд төрсөн эхчүүдийн 42,2 хувь нь Улаанбаатар хотод төржээ.

Нийт төрсөн эхчүүдээс 36 эх эндсэн тохиолдол гарсан нь 100000 амьд төрөлтөд 89,5 болж өмнөх оны мөн үеэс 16,8 просантимилээр өсжээ. 2007 оны эхний 9 сарын байдлаар Архангай, Баян-Өлгий, Баянхонгор, Хөвсгөл аймгуудад тус тус 1, Улаанбаатар хотод 2 эх эндсэн байна.

Улсын хэмжээнд нялхасын эндэгдэл амьд төрсөн 1000 хүүхдэд 18,1 байгаа нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад ялимгүй буурсан үзүүлэлттэй байгаа боловч (өнгөрсөн оны мөн үед 1000 амьд төрөлтөд 19,7) эндэгдлийн үзүүлэлт аймаг бүрт харилцан адилгүй байна. Тухайлбал: эндэгдэлийн байдлаар Говь-Алтай аймаг хамгийн өндөр (32,3), Өвөрхангай(29,6), Хөвсгөл(28,0), Дорноговь(23,7), Булган (22,1), Өмнөговь (21,5), Ховд (20,8), Баянхонгор (21,2) зэрэг аймгуудад улсын дундажаас 1.1-1,8 дахин өндөр байна.

Улсын хэмжээнд 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл амьд төрсөн 1000 хүүхэд тутамд 22,6 байгаа нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад (өнгөрсөн оны мөн үед 24,3) буурсан үзүүлэлттэй байна. Увс(41,7), Говь-Алтай(37,8), Өвөрхангай(32,9), Хөвсгөл (31,2), Сүхбаатар(30,0), Булган(28,9), Ховд(26,3), Өмнөговь(27,7), Завхан(25,9), Баян-Өлгий (24,5), Говьсүмбэр(23,0), аймгуудад улсын дундажаас өндөр байна.

2007 оны эхний 9 сарын байдлаар улсын хэмжээнд нас баралтын 11238 тохиолдол бүртгэгдсэний 19,9 хувийг осол гэмтлийн шалтгаант нас баралт эзэлж байна. Нийт нас баралтын 24,7 хувь нь эмнэлэгт нас барсан байна. Харин эмнэлгийн нас баралтын 23,1 хувийг хоног болоогүй нас баралт эзэлж байна.

Осол гэмтлийн шалтгаант нас баралтын 18,0 хувийг амиа хорлосон, 16,3 хувийг зам тээврийн ослын улмаас, 11,5 хувийг бусдад хорлогдсон нас баралт үлдэх 48,3 хувийг бусад ослын шалтгаант нас баралт тус тус эзэлж байна.

2007 оны эхний 9 сарын байдлаар улсын хэмжээгээр халдварт өвчний 29864 тохиолдол бүртгэгдэж 10000 хүн амд 114,3 ногдож байна. Нийт бүртгэгдсэн хурц халдварт

өвчний 30,8 хувийг зонхилон тохиолдох бэлгийн замаар дамжих халдвар, 21,3 хувийг улаанууд, 13,6 хувийг вируст гепатит, 11,9 хувийг сүрьеэ, 3,1 хувийг салхин цэцгийн өвчлөл тус тус эзэлж байна.

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад цусан суулга өвчний тохиолдол өссөн байна. Өвчлөл Хэнтий, Говьсүмбэр, Өвөрхангай, аймагт илүүтэй бүртгэгдсэн байна.

Улаануудын өвчлөл эхний 9 сарын байдлаар 6347 тохиолдол бүртгэгдэж 10000 хүн амьд 24,3 болж өссөн байна. Нийт улаанууд өвчлөлийн 40,2 хувь нь Улаанбаатар хотод бүртгэгдсэн байна.

Сүрьеэ өвчний 3558 тохиолдол бүртгэгдэж, 10000 хүн амд 13,6 ногдож байна. Өвчлөл Дархан-Уул(26,1), Дорнод(22,3), Сэлэнгэ(21,1), Улаанбаатар хот(19,3), Хэнтий (19,2), Говьсүмбэр(18,6), Сүхбаатар(13,6), эдгээр аймгуудад улсын дунджаас өндөр байна.

Салхинцэцэг өвчний гаралтын байдал өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 482 тохиолдлоор ихэссэн ба 10000 хүн амд 5,7 ногдож байна. Өвчлөл Дорнод(9,5), Хэнтий(9,0), Өвөрхангай(8,6), Баянхонгор(8,7), Архангай(7,6), Сэлэнгэ(7,6), Булган(6,6), Хөвсгөл(6,4), аймаг болон Улаанбаатар хотод улсын дунджаас өндөр байна.

Улаанбурхан өвчлөлийн 16 тохиолдол бүртгэгдэж 10000 хүн амд 0,1 байна.

Зонхилон тохиолдох бэлгийн замаар дамжих халдварт өвчний нийт 9219 тохиолдлоос 35,6 хувийг трихомоноз, 36,8 хувийг заг хүйтэн, 27,5 хувийг тэмбүү өвчин тус тус эзэлж байна. Тэмбүү өвчлөлийн улсын дундаж 9,7 байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс ихэссэн бөгөөд Дархан-Уул(29,1), Говьсүмбэр(17,0), Баянхонгор(16,2), Хэнтий(13,7), Улаанбаатар(13,4), Говь-Алтай(13,0), Дорнод(12,4), Сэлэнгэ(11,0), аймгуудад улсын дунджаас өндөр байна.

Энэ оны эхний 9 сарын байдлаар халдварт өвчний улмаас нас барсан 119 тохиолдлын 71 нь сүрьеэгийн улмаас, 28 нь вируст гепатитын улмаас, 9 нь менингококкт халдварын улмаас, 2 нь төрөлхийн тэмбүүгийн улмаас, 2 нь балнадын улмаас, 2 нь хүний боом өвчний улмаас, цусан суулга, сальмонеллээ, салхинцэцэг, тарваган тахал өвчний улмаас тус тус 1 нас барсан байна.

Санхүү, эдийн засгийн чиглэлээр:

Үйлдвэр, худалдааны салбарт:

Байгаль орчны салбарт

“Байгаль орчныг хамгаалах тухай” болон “Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль”-д нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулан яамдаас санал авч, Засгийн газарт хүргүүлээд байгаагийн зэрэгцээ “ТХГН-н тухай” болон “ТХГН-н орчны бүсийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай” хуулийн төслийн үзэл баримтлалыг эцэслэн боловсруулж төв орон нутгийн ажилтнуудаар хэлэлцүүлээ.

Байгаль орчинд сөрөг нөлөөлөл үзүүлсний төлбөрийн тухай хуулийн үзэл баримтлал, “Ан агнуурын тухай” хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай, “Импортоор оруулсан дахин ашиглах боломжгүй бараа материал, хог хаягдалд төлбөр тооцох тухай хууль”-ийн төслийг боловсруулж байна.

“Озоны үе давхаргыг задалдаг бодисын тухай” монреалын протоколд оруулсан Бээжингийн нэмэлт өөрчлөлтөд нэгдэн орох тухай асуудлыг УИХ-ын чуулганаар хэлэлцүүлж батлуулав.

“Хүн амыг эрүүл ахуйн шаардлагад нийцсэн ундны усаар хангах хөтөлбөр” “Ган, цөлжилт, хуурайшилтын зэрэглэл тогтоох ба энэ үед мөрдөх усны нөөцийн менежментийн журам”-ыг засгийн газраар хэлэлцүүлэн батлуулсны дээр, “Монгол улсын хэмжээнд химийн бодис ашиглан алт олборлож буй иргэд, аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны тухай” танилцуулгыг Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн ажлын албанд, хүргүүлэв.

“Мөнгөн ус, цианидаар бохирдсон хаягдлыг хамгаалалтанд авах арга хэмжээний тухай” Байгаль орчны сайдын албан даалгавар гаргаж, Агаарын чанарын асуудал эрхэлсэн улсын албаны дүрмийг батлуулан мөрдүүлж эхэлсний дээр, “Ойн сангийн тодорхой хэсгийг нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагад гэрээгээр эзэмшүүлэх”, “Ой зохион байгуулалт хийх журам”-ууд, Иргэн, нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагаас худалдаж авах таримал ой, модны жишиг үнийн төсөл, гар аргаар алт олборлодог иргэдийг ашиглалт явуулсан талбайд биологийн нөхөн сэргээлт хийлгэх замаар ажлын байраар хангах саналыг боловсрууллаа.

Хоёр. Бодлогын хэрэгжилтийн талаар

Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээний 78 дүгнэлт гаргаж, нарийвчилсан үнэлгээний 16 тайланг хэлэлцэн 9 тайланг баталж, 2 тайланг батлах боломжгүй гэж үзэн, 5 тайланг нэмэлт засвар, өөрчлөлт оруулахаар буцааж, 24 аж ахуйн нэгжид химийн бодис импортлох зөвшөөрөл олгоод байна.

Байгаль орчны яамны интернэт хуудсанд үнэлгээний эрх бүхий аж ахуйн нэгжүүдийн жагсаалт, байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээ хийлгэхэд шаардагдах материалын жагсаалт, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний эрх авахад шаардлагатай материалын жагсаалт зэрэг материалыг байрлуулан олон нийтэд мэдээлэв.

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний эрх авахаар хүсэлтээ ирүүлсэн 10 аж ахуйн нэгжийн материалыг хүлээн авч 7 аж ахуйн нэгжид эрх олгов.

Ховд, Увс аймгийн хилийн заагт орших Алтайн хөхийн нуруу, Говь-Алтай, Завхан аймгийн хилийн заагт орших Хунгийн хар нуур, Монгол элс түүний орчмыг улсын тусгай хамгаалалтад авах судалгааны ажлыг хангаж байна.

Байгаль цаг уурын нөхцөл хүндэрч болзошгүй нөхцөлд Хамгаалалтын 13 захиргааны харьяа нутагт 1409 өрх буюу 493346. тоо толгой бүхий малыг өвөлжүүлэх боломжтой гэсэн судалгааг гаргаж зөвшөөрлийг холбогдох аймаг сумдад хүргүүлэв. Мөнххайрхан, Говь Гурвансайханы БЦГ-ын хамгаалалтын захиргаад Хүрэн шанд, Сүүж булгийн эхэнд Баян-Өлгий аймгийн Булган сумын нутагт ан амьтдад зориулж хужир шүү тавьж биотехникийн арга хэмжээ авч хэрэгжүүлэв.

-Хөвсгөл аймгийн Баянзүрх сумын нутагт хулгайгаар алт олборлож эхэлсэн мэдээллийн мөрөөр шалгаж хууль бус үйл ажиллагааг газар дээр нь таслан зогсоож түүнд оролцсон иргэдийг цагдаагийн байгууллагад шилжүүлээд байна.

-“Дархан-Уул аймгийн Хонгор суманд мөнгөн ус, цианид ашиглан хууль бусаар алтны хүдэр, шлам боловсруулсан үйл ажиллагаанаас үүссэн бохирдлыг арилгах талаар цогц арга хэмжээг авч хэрэгжүүлэв. Энэхүү ажлын хүрээнд бохирдсон 1192 тонн шлам, хаягдлыг “Бороо гоулд” ХХК-ийн хаягдлын сан руу зөөж, цэвэрлэх байгууламжийн тунгаагуур, лагийн сан, худаг, шугам хоолой, хаягдал усны цөөрмийн бохирдсон 34802м² талбай болон 18,5 тн цианидийн уусмалыг хоргүйжүүлж, гүний худагт шавхалт хийн, сургуулийн мэдээлэл зүйн танхимын шалыг хуулж, бохирдсон шороог зайлуулан хоргүйжүүлэх арга хэмжээг авлаа.

Болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор Дархан-Уул аймгийн Засаг даргын Тамгын газраас Хонгор сумын төвд тариалсан нийт 136.8 тн хүнсний ногоог зохион

байгуулалттайгаар хураан авсан бөгөөд үүний 40.3 тн нь шинжилгээгээр мөнгөн ус, цианид илэрсэн нэр бүхий 7 айлын ногоо болно.

Хордлогын голомтыг устгаж аюулгүй болгосноос хойш мал, амьтан дахин хордлогын шинж тэмдэгтэй өвчлөөгүй, хорогдоогүй байна.

9 дүгээр сард хийсэн шинжилгээний дүнг үндэслэн мөнгөн ус шинээр илэрсэн нийт 2561 м² талбайд саармагжуулалт хийлээ. Хордлогын шинж тэмдэг бүхий хүмүүсийг бүрэн хяналтанд авч, эмчлэн эрүүлжүүлэх үйл ажиллагаа үр дүнтэй хийгдэж байгааг үндэслэн Хонгор сумын хүн амыг нүүлгэн шилжүүлэх шаардлагагүй гэсэн дүгнэлтэд хүрээд байна.

“Байгаль хамгаалах өдрүүд” болон “Нийслэлийн өдөр”-ийг угтаж зохион байгуулсан цэвэрлэгээний ажилд төвийн 6 дүүргийн 111 хорооны 1411 аж ахуйн нэгж, 18067 иргэд оролцон 119,4 га талбайн 5397 тн хогийг цэвэрлэж, төвлөрсөн цэгт буулгасан бөгөөд энэ ажилд Хог хаягдлын үйлчилгээний сангаас 26911.2 мян.төг, ТҮК-иас 9835.0 мян.төгрөг, аж ахуйн нэгж байгууллагаас 11387.0 мян.төгрөг буюу нийт 48133.2 мян.төгрөг зарцуулсан байна.

БНСУ-ны Байгаль орчны яам, байгаль орчны хүрээлэнд хандан Дархан-Уул, Орхон аймгийн хог хаягдлын мастер төлөвлөгөөг боловсруулах, холбогдох ажилтныг сургалтанд хамруулах талаар төслийн санал боловсруулж хүргүүлээд байна.

2007 оны төсвийн тодотголоор Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээнд зарцуулахаар тусгагдсан 2.0 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий ажлыг

-Шинэ технологийн утаагүй, халаалтын эх үүсвэрээр гэр хорооллыг хангах;

- Байгальд халгүй шахмал түлшний үйлдвэрлэлийг дэмжих;

-Үртсэн түлшний үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлэх;

-Нам даралтын халаалтын зуухнуудыг шинэчилж, цахилгаан халаагуураар солих гэсэн дөрвөн чиглэлээр аж ахуйн нэгжүүдтэй гэрээ байгуулах замаар хэрэгжүүлж байна.

Одоогоор танигдаагүй хархны талаарх судалгааг Увс аймгийн Тэс сумын нутагт, Загасны нөөцөд асар их хохирол учруулж байгаа хар галууны талаар судалгаа явуулах нүүдлийн экспедицийг Хөвсгөл аймгийн Цагаан нуурт томилон ажиллуулж байна

Дундговь, Дорноговь аймгуудын 217.0 мянган га заган ойд ой зохион байгуулах ажлын хээрийн судалгааны ажлыг явуулж, Төв аймгийн ойн санд хийсэн хээрийн судалгаагаар 1830 мянган га талбайг агаарын гэрэл зургаас байр зүйн зурагт буулгах ажлыг бүрэн дуусгаад байна.

Засгийн газрын нэмэлт хөрөнгөөр гүйцэтгэх ойн хөнөөлт шавжтай тэмцэх ажлыг Төв аймгийн Батсүмбэр, Мөнгөнморьт сумын нутагт 2000 га-д, Хэнтий аймгийн Өмнөдэлгэр, Биндэр сумдын нутагт 1000 га-д, Өрөөсгөл хүр эрвээхэйн өндгийг түүж устгах ажлыг Сэлэнгэ аймгийн Мандал сумын нутагт 1000 га-д, Улаанбаатар хотын ногоон бүсийн Ар гүнт, Жаргалант, Шар хад, Цагаанчулуут, Бороож, Халзан зэрэг амуудад 500 га-д тус тус хийж гүйцэтгээд байна.

Байгууллага, аж ахуйн нэгжүүдийн захиалгаар мод бэлтгэх талбайг тусгаарлах, түймэрт шатсан, хөнөөлт шавжид идэгдсэн ойд дүгнэлт гаргах захиалгат ажлыг нийт 29 га талбайд 3 удаа хийж, материалыг хүлээлгэн өгсөн.

Усны нөөц ашиглуулах тухай мэргэжлийн дүгнэлтийг

• “Алтан дорнод Монгол” ХХК,

• “Гидрофонтан” ХХК,

• “Шижир Алт” ХХК-ийн Заамар дахь алтны шороон орд,

• “САТУ” ХХК-д боловсруулсан “Налайх дүүргийн нутагт сэргээгдэх эрчим хүчний цэцэрлэг,

• “Суруга Монгол” ХХК-ийн Угсармал бетон үйлдвэрлэх байгууламж

• Туул голын гольдрилыг хайгуулын 670-676 дугаар шугамын хооронд түр өөрчлөх, үндсэн гольдрилд нь оруулах ажил, түүний байгаль орчны өөрчлөлт, хохирол, түүнийг багасгах арга хэмжээний зураг төсөл гаргав.

Улаанбаатар хотын Сонгино хайрхан, Сүхбаатар дүүргийн 4 булгийн эхийг тохижуулан хашиж, хамгаалах, “Өвөрхангай аймгийн Богд суманд Ховд голын цөөрөм барих, “Төв аймгийн Алтанбулаг сумын Ширээ хүүшийн хөв барих, “Говь-

Алтай аймгийн Тонхил сумын Цагаан хөшөөтийн хиймэл усан сангийн засварын ажлуудын гэрээ байгуулах ажлыг эхлүүлээд байна.

Гурав. Цаг уурын мэдээлэл, орчны шинжилгээний ажил

Цаг агаарын урьдчилсан мэдээний ерөнхий таарц төлөвлөгөөт даалгавраас 7.3-11.9 хувиар дээгүүр, өнгөрсөн оны мөн үеэс бүх төрлөөрөө 0.4-12.9%-иар ахив.

Сарын цаг агаарын урьдчилсан мэдээний таарц 80.9 хувь болж өнгөрсөн оноос 2.2% илүү, төлөвлөгөөт даалгавраас 18.9% дээгүүр байна.

ТВ-ийн 8 студи, радиогийн 3, сонины 8, бусад 6 байгууллагад цаг агаарын нийтийн хэрэгцээний болон тусгай хэрэгцээний мэдээгээр нийтлэх, нэвтрүүлэх ажлыг зохицуулж байна.

1-7 хоногийн цаг агаарын тойм, 7 хоногийн төлөв, 5 хоногийн урьдчилсан мэдээ, Улаанбаатар хотын нарийвчилсан мэдээ, үүлний зургийг веб хуудсанд тавих ажлыг тасралтгүй хийж байна

Тайлангийн хугацаанд олон улсын шугамд ниссэн 179, орон нутгийн 196 нислэгт цаг агаарын мэдээгээр үйлчилж, Чингис хаан олон улсын нисэх буудлын 9 цагийн урьдчилсан мэдээ 248 удаа зохиосноос таарц нь 88.0 % байна.

Нислэгт зориулж районы урьдчилсан мэдээ 124, угталтын урьдчилсан мэдээ 6, нислэгийн замын дагуух аюултай үзэгдлийн урьдчилсан мэдээ 9 удаа тус тус зохиож үйлчилсний дээр бүх төрлийн урьдчилсан мэдээний дундаж таарц 97.2% байсан ба Тосонцэнгэлийн нисэх буудлыг урьдчилсан мэдээгээр үйлчилж, таарц 94.5% байв. Мөн Оюутолгойн нисэх буудлын нислэгийн цаг агаарын мэдээний хангалтыг хариуцан гүйцэтгэлээ.

Цаг агаарын мэдээний хангалттай холбоотой нислэгийн саатал, зөрчил гараагүй байна.

Орон нутгийн Урьдчилсан мэдээлэх товчоод цочир хүйтрэлээр 71 удаа хоногийн сэрэмжлүүлэг мэдээ зарласан. Сэрэмжлүүлэх мэдээний чанар 84.9%, онц 91.5%-тай байна.

Хөдөө аж ахуйн цаг уурын 10 хоногийн тоймын 25-27 дугаарыг хэвлэн гаргав. Мөн усны горимын арав хоногийн тоймыг 3 удаа ХАА-н цаг уурын мэдээлэлд оруулав. Гол мөрний хадаалах хугацааны прогнозыг 20 гол харуулаар гаргаж, сарын мэдээнд орууллаа.

Европ, Ази тивийг хамарсан цаг уурын газар орчмын 1000 гаруй станцаас өдөр бүр 3 цаг тутам, өндрийн мэдээллийн 250 орчим станцаас цаг агаарын бодит байдлын мэдээллийг хүлээн авч боловсруулан цаг агаарын мэдээ гаргахад ашиглав.

Хустай, Сэлбэ голын хөрсний чийг болон бэлчээрийн ургамлын судалгаа, Сэлэнгэ аймгийн Цагааннуурын таримал, Ерөө, Орхон, Баруунхараагийн бэлчээрийн болон тариалангийн талбайд хөрсний агро-ус зүйн шинж чанар тодорхойлох ажлыг гүйцэтгэв.

Улаанбаатар хотын агаарын бохирдлыг хянах 4 харуулын шинжилгээний дүнгээс харахад хүхэрлэг хийн дундаж агууламж нийт 94 удаагийн ажиглалтаар Агаарын чанарын стандарт дахь хүлцэх агууламжаас давсан бохирдол ажиглагдаагүй, харин азотын давхар ислийн агууламж нийт 97 удаагийн ажиглалтаас харахад хотын баруун дөрвөн замын орчим 17 удаа, 13 дугаар хороололд 26 удаа давсан байна.

9 дүгээр сарын 29-нд Туул голын хотоос дээш хэсэгт ус бохирдолгүй цэвэр байсан ба Сонгиноос доош хэсэгт аммонийн болон нитритийн азотын агууламж Усны чанарын стандарт дахь хүлцэх агууламжаас 2- 6 дахин, органик бодисын агууламж 1.6- 2.4 дахин давсан бохирдол илэрчээ. Мөн Идэр- Тосонцэнгэл, Завхан- Тайшир, Туул- Лүн харуулын орчим нитритийн азотын агууламж хүлцэх агууламжаас давсан бохирдол илэрсэн байна.

Үйлдвэрийн хаягдал усны Улаанбаатар хотын 5 цэвэрлэх байгууламжийн шинжилгээний дүнгээс үзэхэд Нисэхийн цэвэрлэх байгууламжийн ажиллагаа 91%, Налайхын ЦБ-ийн ажиллагаа 78%, Био орон сууцны цэвэрлэх байгууламжийн хаягдал 28%-ийн цэвэршилттэй байсан байна.

Төв аймгийн Батсүмбэр, Мөнгөнморьт, Эрдэнэ, Хэнтий аймгийн Батширээт, Биндэр сумдын нутагт гарсан ой хөвчийн түймрийг унтраах зорилгоор “Хурын шим” төвийн 2 экспедиц гарган үүлэнд зориудаар нөлөөлөх ажиллагаа явуулсны үр дүнд дээрх сумдын нутгаар 7.4мм-10.8мм тунадас орж, түймрийн 8 голомтыг бүрэн унтраалаа.

Цаг агаарт зориудаар нөлөөлөх 2008 оны үйл ажиллагааны бэлтгэл ажлын хүрээнд БНХАУ-аас JFJ-1И маягийн 200 ширхэг пуужин оруулж ирээд байна.

Дөрөв. Гадаад хамтын ажиллагааны талаар:

Солонгос улс, Өвөр Монголын Туньло хот, Жирмэн аймгийн Хорчин нутагт элсний нүүлт, цөлжилтөөс хамгаалж мод тарьж, ногоон зурвас байгуулж байгаа арга туршлагыг судлах ажлыг зохион байгуулж, Солонгос Монголын “Ногоон хэрэм ойжуулалт” төслийн хүрээнд Арцатын аманд 1000 ширхэг мод тарив.

Өвөр Монголын өөртөө засах орны Ардын Засгийн ордны Дэд тэргүүлэгч Лэй Эрдэнэ тэргүүтэй төлөөлөгчид ногоон хэрэм байгуулах үйл ажиллагаатай танилцан цаашид хамтран ажиллах гэрээнд гарын үсэг зурав.

Барилга, хот байгуулалтын салбарт:

Засгийн газрын “Тусгай сангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай” хуулийн төслийг УИХ-д өргөн барив.

“Хотыг дахин хөгжүүлэх тухай” болон “Орон сууцны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулийн төслийг боловсруулж байна.

“Геодези, зураг зүйн тухай” хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн УИХ-д өргөн барих зөвшөөрөл авахаар Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлэв.

“Хөрөнгийн үнэлгээний тухай” хуулийн төслийг боловсруулж батлагдсан үзэл баримтлал, хуулийн төсөлд яамдаас санал авлаа.

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хуваарийн “Бүлэг суурингийн тогтолцоо”-ны төсөлд холбогдох яамдаас санал авч тусган, тодруулга хийж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлэв.

Ахмад дайчдыг орон сууцжуулах асуудлаар боловсруулсан Засгийн газрын тогтоолын төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж баталгаажуулав.

“Төрийн албан хаагчдын орон сууцны дэд хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг боловсруулж холбогдох газруудад хүргүүлэв.

Засгийн газрын “40000 орон сууц” хөтөлбөрийн хүрээнд Засгийн газрын бондын хөрөнгөөр баригдаж байгаа орон сууцны барилгын явцад хяналт тавьж, үнэлэлт өгч, дүн шинжилгээ хийх ажлын хэсэг ажиллаж байна.

Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах талаар авах арга хэмжээний талаар мэдээлэл бэлтгэж, УИХ-ын Байгаль орчин, хүнс хөдөөд аж ахуйн байнгын хороонд хүргүүллээ. 2008 оны төсөв хэлэлцэхтэй холбогдуулан инженер хангамжийн шинэчилсэн судалгаа гарган танилцуулга, шинээр барих дэд бүтцэд зориулан төсвийн тооцоо хийж байна.

Энэ оны 12 дугаар сард Япон Улсад зохиогдох Зүүн Азийн орнуудын ариун цэврийн байгууламжийн талаархи хурал, зөвлөгөөнд Монголын төлөөлөгчдийн тавих илтгэлийн төслийг бэлтгэх ажлыг НҮБ-ын Хүүхдийг ивээх сантай хамтран боловсруулж байна.

Японы Засгийн газрын буцалтгүй тусламжаар хэрэгжүүлэх “Дархан хотын ус хангамжийг сайжруулах төсөл”-ийг эхлүүлэх бэлтгэл ажлыг зохион байгуулж байна. Японоос ирсэн судалгааны багтай хамтран ажиллаж, шаардлагатай тоо баримт, материалыг нэгтгэн хүргүүлэв.

Хилийн цэсийн маргаантай байгаа аймгуудын хилийн цэсийг тодотгох, санал боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулахаар ерөнхий сайдын захирамжийн төсөл, хилийн цэсийн маргаантай байгаа аймаг сумдын судалгааг танилцуулгын хамтаар Засгийн газрын хэрэг эрхлэх газарт хүргүүлж Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлэв.

Нүүдэлч малчдын судалгааны төвд боловсруулсан “Аймгийн төвд ойролцоо орших сумдыг аймгийн төвтэй нэгтгэх бололцоог тодорхойлох” судалгааны төсөлд 21 аймгийн Засаг даргын Тамгын газар, 7 хот, суурины Захирагчийн ажлын алба, Барилга Архитектур Корпораци зэрэг байгууллагуудаас санал авахаар холбогдох материалыг хүргүүлэв.

Монгол Улсын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хоорондын комиссын ээлжит хуралдаанд оролцов.

БНТУ-ын хот байгуулалт, нутагшил суурьшлын яамны газрын дарга тэргүүтэй төлөөлөгчдийн Монгол Улсад хийсэн айлчлалыг зохион байгуулав.

Зам, тээвэр, аялал жуулчлалын салбарт:

Худалдаа, тээврийг хөнгөвчлөх Үндэсний хорооны хурлыг 9 дүгээр сарын 26-нд зохион байгуулав. Хурлаар Далайд гарцгүй хөгжиж буй орнууд болон дамжин өнгөрүүлэгч орнуудын худалдааны сайд нарын “Худалдаа ба худалдааг хөнгөвчлөх” сэдэвт Олон улсын чуулга уулзалтыг 2007 оны 8 дугаар сарын 28-31-нд Улаанбаатар хотноо зохион байгуулсан тухай мэдээлэл, Монгол Улс, БНХАУ, ОХУ-ын Засгийн газар хоорондын дамжин өнгөрөх тээврийн тухай хэлэлцээрийн төслийн яриа хэлэлцээний явцын тухай, Худалдаа, тээврийг хөнгөвчлөх Үндэсний хорооны 2007 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийн тухай танилцуулга, “Ачааг хилээр нэвтрүүлэхэд хийх хил гаалийн үзлэг шалгалтыг явуулах нөхцөлийн тухай олон улсын конвенц”-ийг хэрэгжүүлэх чиглэлээр Улсын мэргэжлийн хяналтын газраас авч байгаа арга хэмжээний тухай мэдээллийг хэлэлцэв. Мөн “Транзит Монгол” хөтөлбөрийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр тогтов.

“Транс Азийн Төмөр замын сүлжээний тухай” Засгийн газар хоорондын хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг 2007 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн Улсын Их Хурлын нэгдсэн чуулганаар хэлэлцүүлж батлууллаа.

Мянганы сорилын сангаас төмөр замын салбарт хэрэгжүүлэх төслийн талаар Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороо, нэгдсэн чуулганд танилцуулав. Уг сангаас нийт 285 сая ам. долларын санхүүжилтийн тусламжийг Монголд үзүүлэхээс төмөр замын салбарт 188 сая ам. долларын тусламжийг үзүүлэхээр тохироод байгаа юм. Энэхүү тусламжийн гэрээнд Монгол Улсын Ерөнхийлөгч энэ сард АНУ-д айлчлах үеэр гарын үсэг зурлаа.

Монгол Улсын Засгийн газар, Австрийн Холбооны Улсын Засгийн газар хооронд 1999 онд үзэглэсэн Агаарын харилцааны тухай хэлэлцээрт нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн дэмжүүлж улмаар Монгол Улсын Ерөнхий сайдын Австрийн Холбооны Улсад хийх айлчлалын үеэр энэ оны 10 дугаар сарын 02-ны өдөр гарын үсэг зурж ёсчлов.

“МИАТ” ХК-ийн агаарын хөлгийн паркийн шинэчлэлт, хувьчлалын тухай асуудлыг 9 дүгээр сарын 26-ны өдрийн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд танилцуулахаар шийдвэр гаргуулав.

Улаанбаатар хотод олон улсын шинэ нисэх буудал байгуулах төслийн эцсийн судалгааг Япон Улсын Олон улсын хамтын ажиллагааны банкнаас томилогдсон судалгааны баг гүйцэтгэж, техник, эдийн засгийн үндэслэлийг хийж дуусгав. Японы талаас Олон улсын хамтын ажиллагааны банк, Монголын талаас Сангийн яам, Зам, тээвэр аялал жуулчлалын яам, Иргэний нисэхийн ерөнхий газрын төлөөлөл төслийн үнэлгээний зарчмыг тохирох Санамж бичгийг 10 дугаар сарын 9-ний өдөр үзэглэв.

Зам, Тээвэр, аялал жуулчлалын сайдын 2007 оны 146 дугаар тушаалаар Далайн захиргааг байгуулж, түүний бүтэц, дүрмийг баталж, даргыг нь томиллоо. Үүнтэй холбогдуулан Далайн захиргааг үйл ажиллагаагаа хэвийн явуулах нөхцөл, боломжоор хангаж шаардлагатай асуудлуудыг нь шийдвэрлэж өглөө.

Хөвсгөл-Байгаль нуурын орчимд аялал жуулчлалыг хөгжүүлэх хөтөлбөрийн төслийг Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, Аялал жуулчлал хөгжүүлэх стратегитай уялдуулан боловсруулж дуусгав.

Улсын Их Хурлын Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороо, Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны хамтарсан удирдамжийн хүрээнд гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авч ажиллуулж буй зарим аялал жуулчлалын аж ахуйн нэгж, байгууллагуудын /зочид буудал, жуулчны бааз, тур-оператор, зоогийн газар/ үйл ажиллагаатай танилцан шалгаж, тулгамдаж буй асуудлыг хууль, эрх зүйн баримт бичиг, бодлогод тусгаж шийдвэрлэх талаар санал боловсруулж хүргүүлэв.

Аялал жуулчлалын зах зээлийн эрэлт хэрэгцээ шаардлагын дагуу жуулчны үйлчилгээний байгууллагууд олноор байгуулагдан үйл явуулж байгаа бөгөөд тэдгээрийг ангилах, тавигдах шаардлагыг тодорхой болгох үүднээс Аялал жуулчлалын байршлын хэрэгслийн стандартын төслийг боловсруулав. Тус стандартыг Аялал жуулчлал, зочид буудлын стандартын дэд хорооны хурлаар 10 дугаар сарын 9, 17-ны өдрүүдэд 2 удаа хэлэлцүүлээд байна.

Аялал жуулчлал хөгжүүлэх бүс нутаг тогтоох тухай асуудлаар Байгаль орчны яам, Газрын харилцаа, геодези зураг зүйн газар, аймгуудын Засаг даргын Тамгын газар, байгаль орчны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төсөл, хөтөлбөрүүдтэй хамтран ажиллаж байна. Тус ажлын хүрээнд аймгуудаас ирүүлсэн мэдээллийг нэгтгэж боловсруулалт хийж байгаагаас гадна БОЯ, Дэлхийн байгаль хамгаалах нийгэмлэг /WWF/, Германы техникийн хамтын ажиллагааны нийгэмлэг /GTZ/, Нэгдсэн үндэстний байгууллагын хөгжлийн хөтөлбөр /UNDP/, “Аялал жуулчлалын тогтвортой хөгжлийн төв” ТББ-тай хамтран аялал жуулчлал хөгжүүлэх бүс нутаг тогтоох, түүний аргачлалыг боловсруулах асуудлаар уулзалт, ярилцлага зохион байгуулав.

Нэгдсэн үндэстний байгууллагын хөгжлийн хөтөлбөрөөс хэрэгжүүлж буй “Нэг суурин, Нэг бүтээгдэхүүн” төсөлтэй хамтран ажиллаж байгаа бөгөөд энэ оны 10 дугаар сарын 12-13-ны өдрүүдэд “Нэг Суурин-Нэг бүтээгдэхүүн уриан дор үндэсний үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, хөгжлийн хурдцыг түргэтгэе” сэдэвт Үндэсний зөвлөгөөнийг хамтран зохион байгуулав. Тус хөтөлбөрийн нэг бүрэлдэхүүн хэсэг нь нутгийн иргэдэд тулгуурласан аялал жуулчлалыг хөгжүүлэх асуудал бөгөөд энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй нутгийн иргэдэд удирдамж, зөвлөгөө өгч ажиллав.

Монгол Улсын Шинжлэх ухаан технологийн сангаас Зам, тээвэр, аялал жуулчлалын салбарт 2008 оноос санхүүжүүлэх төслүүдийг “Шинжлэх ухаан, технологийн төсөл хэрэгжүүлэх, санхүүжүүлэх тухай журам”-ын дагуу сонгон шалгаруулав.

Монгол Улсын Ерөнхийлөгч Кувейт, Катар, Арабын нэгдсэн Эмират улсуудад албан ёсны айлчлал хийхтэй холбогдуулан яриа хэлэлцээний сэдэвд баруун босоо тэнхлэгийн Ярант-Ховд-Өлгий-Цагааннуур чиглэлийн 300 км замыг Арабын нэгдсэн Эмират улсын хөнгөлөлттэй зээлээр барих саналыг Гадаад хэргийн яаманд хүргүүлэв.

ХБНГУ-ын KfW банкны хөнгөлөлттэй зээлээр “Улаанбаатар хотын хүнсний хангамжийг сайжруулах бүс нутгийн тээврийн дэд бүтцийг сайжруулах” төслийн хүрээнд Батсүмбэр, Борнуур, Жаргалант сумын замыг сайжруулах саналыг Сангийн яаманд хүргүүлсэн ба зээлийн хүүгийн хэмжээг тохиролцох шатанд санал хүлээгдэж байна.

Авто замын салбарт улсын төсөв, замын сан болон Монгол Улсыг хөгжүүлэх сангийн хөрөнгөөр 2007 онд хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийг 10 дугаар сарын 1-ний өдрийн байдлаар гаргаж энэ оны гүйцэтгэлд үнэлэлт дүгнэлт өгч, 2008 онд авто замын салбарт хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхэд анхаарах асуудлыг боловсруулан Хөрөнгө оруулалтад хяналт тавих зөвлөлд танилцуулав.

Ховд аймгийн Булган сум, БНХАУ-ын ШУӨЗО-ны Чингэл сумын чиглэлд улс хоорондын нийтийн зорчигч тээврийн үйлчилгээг эрхлэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерт ялсан “Хөрс-Автосервис” ХХК-д Зам, тээвэр, аялал жуулчлалын сайдын 165 дугаар тушаалаар нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгов.

Их багтаамжийн автобусаар хот хоорондын нийтийн зорчигч тээврийн үйлчилгээ эрхлэх техник ашиглалтын үндсэн шаардлагыг хангасан “Дайчин чадвар” ХХК-ид хот хоорондын нийтийн зорчигч тээвэр, шуудан тээвэрлэлтийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг сайдын 160 дугаар тушаалаар олгож уг тушаалаар боломжтой чиглэлд үйлчилгээ эрхлэх гэрээ байгуулахыг Тээврийн үйлчилгээний төвд үүрэг болгов.

Нүүрсний нөөцлөлтийг нэмэгдүүлэх, уурхайнуудын вагон хангалтыг сайжруулах талаар “УБТЗ”-д үүрэг өгөгдсөний дагуу Замын даргын 155 дугаар тушаал гарч өвөлжилтийн дэглэмд шилжиж, нүүрс хангалтыг сайжруулах арга хэмжээ авч эхэллээ. Уг арга хэмжээг авахаас өмнө дулааны цахилгаан станцуудын нөөц, тухайлбал, Эрдэнэтийнх 2 хоног байсан бол энэ арга хэмжээг авснаар 13 хоног болж нэмэгдэж байгаа.

Төмөр замын Хэрэг эрхлэх газрын зохион байгуулалт, бүтцийг Сайдын тушаалаар шинэчлэн баталлаа.

Далайн салбарт мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэх ажлын хүрээнд ОХУ-ын Алс дорнодын Далайн их сургуульд суралцах оюутнуудын виз, урилгын мэдүүлгийг авч ОХУ-аас Монгол Улсад суугаа Элчин сайдын яаманд хүргүүлж,

сургалтын гурвалсан гэрээг тус их сургууль, Тээврийн газар, оюутан хооронд байгуулах ажлыг зохион байгуулав.

Монголын талаархи сурталчилгааны ерөнхий танилцуулга, 2008 оны нарны бүтэн хиртэлтийн талаархи англи хэл дээрхи нугалбаруудыг бэлтгэж хэвлүүлэв. 2008 оны 8 дугаар сарын 1-нд болох нарны бүтэн хиртэлтийн үеэр арга хэмжээ зохион байгуулах, тээврийн асуудлыг шийдвэрлэх талаар холбогдох байгууллагуудтай хамтран ажиллаж байна.

Жуулчдын тоо 2007 оны эхний 9 сарын байдлаар 337 мянгад хүрсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 6,2 хувиар өссөн байна.

Авто замын салбарт 2007 онд улсын төсөв болон “Монгол Улсыг хөгжүүлэх сангаас 67.5 тэрбум төгрөг, гадаадын зээл тусламжаар 45.5 сая долларын хөрөнгө төлөвлөгдсөний дагуу нийт 52 гүйцэтгэгчтэй гэрээ байгуулан ажилласнаас он дамжсан 13, шинээр 35 гүйцэтгэгчтэй аж ахуйн гэрээ байгуулан ажиллаж байна. Нийт барилгын ажлын гүйцэтгэл 2007 оны 10 дугаар сарын 22-ны байдлаар ажлын гүйцэтгэл 56.98%-тай байна.

Баруун босоо тэнхлэгийн Ярант-Ховд-Өлгий-Цагааннуур чиглэлийн 300 км замын инженерийн нарийвчилсан зураг төслийг боловсруулах зөвлөхийг сонгох тендерийн баримт бичгийг боловсруулж тендер зарлав.

Кувейтийн сангийн хөнгөлөлттэй зээлээр хэрэгжиж байгаа Эрдэнэт-Булган-Уньт чиглэлийн авто замын Булган-Уньт чиглэлийн авто замын гүйцэтгэгч “Насны зам” ХХК, мөн “Бүс нутгийн авто зам хөгжүүлэх” төслийн А, Б1 багцуудын гүйцэтгэгч нар, зөвлөх компаниудын удирдлагуудтай уулзаж ажлын явцыг түргэтгэх, тулгарч байгаа асуудлуудыг ярилцан сарын хугацаатай үүрэг даалгавар өглөө.

Авто зам, замын байгууламжийг барих, засварлах ажлын тусгай зөвшөөрлийг 25 аж ахуйн нэгжид Сайдын тушаалаар гарган олголоо.

Яам Авто, замын хяналт, судалгааны төвийн хамтарсан ажлын хэсэг Дархан-Уул, Орхон, Булган, Хөвсгөл, Завхан, Архангай, Өвөрхангай, Баянхонгор аймгуудад албан томилолтоор 12 хоног ажиллаж улсын төсөв, замын сангийн хөрөнгөөр 2007 онд хийгдэж байгаа зам замын байгууламжийн засвар арчлалтын ажлын гүйцэтгэл, явц, чанар, график төлөвлөгөөний биелэлт, өвөлжилтийн бэлтгэл хангасан байдал, шуурхай хэсэг ажиллуулах шаардлагатай хэсгүүдийг газар дээр нь үзэж танилцлаа.

Сангийн яамнаас эрх нээгдэн орж ирсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний санхүүжилтэд нийтдээ 21 аж ахуйн нэгж байгууллагад 4175.3 тэрбум төгрөгний санхүүжилт олгов.

Улсын төсөв болон замын сан, Монгол Улсыг хөгжүүлэх сангаас санхүүжигдэх хөрөнгө оруулалт барилга байгууламж, төсөл арга хэмжээний 2007 оны гүйцэтгэлийн зардлаас норм нормативын санд 133.1 сая төгрөг, баталгаа барьцааны дансанд 246.3 сая төгрөг тус тус төвлөрүүлээд байна.

Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2008 онд хөгжүүлэх Үндсэн чиглэлийн төсөлд тусгах зам, тээвэр, аялал жуулчлалын салбарын бодлого чиглэлд дахин

тодотгол, танилцуулга хийж Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороогоор хэлэлцүүлэв.

Түлш, эрчим хүчний салбарт:

Тус яамнаас 2007 оны 10 дугаар сард Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, эдийн засаг ниймийг 2007 онд хөгжүүлэх Үндсэн чиглэл, Засгийн газрын үйл ажиллагааны тэргүүлэх 10 чиглэлд түлш, эрчим хүчний салбарын талаар тусгагдсан арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх хүрээнд яамны 2007 оны бүтээгдэхүүн нийлүүлэлтийг хангах үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан баталж түүний дагуу дараах үндсэн чиглэлүүдээр холбогдох ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

Нэг. Удирдлага, зохион байгуулалтын чиглэлээр:

Яамнаас тайлант хугацаанд Засгийн газрын 6 тогтоол, хуралдааны 3 тэмдэглэл ирснийг хяналтад авч, хэрэгжүүлэх зохион байгуулалтын арга хэмжээг авч ажиллалаа.

2007 онд Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх асуудлын төлөвлөгөөний дагуу 11 дүгээр сарын тодотголыг хүргүүлэн ажиллалаа.

Түлш, эрчим хүчний салбарын удирдлагын шуурхай зөвлөлгөөнийг 5 удаа зохион байгуулснаас 44 үүрэг даалгавар өгөгдөж, биелсэн 36, хэрэгжих шатанд 6, хугацаа болоогүй 2 асуудал, үүрэг даалгаврын хэрэгжилт 95 хувьтай байна.

Сайд, Төрийн нарийн бичгийн даргаас гаргах шийдвэрийн хууль зүйн үндэслэлийг хянаж, боловсруулахад нь дэмжлэг үзүүлэн, шийдвэрийн биелэлтэд нь хяналт тавьж ажилласнаас Сайдын 8, Төрийн нарийн бичгийн даргын 11 тушаал гарч, хэрэгжилтийг нь ханган ажиллаж байна.

Сайдтай уулзах иргэн, албан тушаалтны хүсэлтийг хүлээн авч уулзалтыг зохион байгуулах, тэмдэглэл хөтлөх, холбогдох албан тушаалтанд сайдаас өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтэд хяналт тавьж, мэдээлэх ажлыг тухай бүр зохион байгуулан ажиллалаа.

Түлш, эрчим хүчний салбар үүсэн байгуулагдсаны 85 жилийн ойн арга хэмжээг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хэсгээс төлөвлөгөөний дагуу ажиллаж байна.

10 дугаар сард нийт 316 албан бичиг ирснээс хяналтад 215, үүний шийдвэрлэлт 90 хувьтай, явсан 262 албан бичиг байна.

Түүнчлэн 17 өргөдөл ирснээс хариу өгсөн 4, хяналтад 3, хугацаа болоогүй 10 байна. Эдгээрийг “Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд хандаж гаргасан өргөдөл, гомдлын хянан шийдвэрлэх тухай” хууль /МУИХ-1995.04.17/-ийн дагуу хянан шийдвэрлэж байна.

Түлш, эрчим хүчний салбарын “Нээлттэй хаалганы өдөр”-ийг 2007 оны 10 дугаар сарын 20-ны өдөр зохион байгуулж салбарын хэмжээнд мөрдөгдөж буй хууль тогтоомж, 2007 оны үйл ажиллагааны тэргүүлэх зорилт, цаашдын хөгжлийн чиг хандлагын талаар санал бодлоо чөлөөтэй солилцон ажиллаж тайланг нэгтгэн Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүллээ.

Засгийн газраас 2007 оныг “Их бүтээн байгуулалт-шинэ ажлын байр нэмэгдүүлэх жил” болгон зарласантай холбогдуулан гаргасан 2007 оны 71 дүгээр тогтоолоор өгөгдсөн үүргийн дагуу Түлш, эрчим хүчний салбарын хэмжээнд улсын төсөв, Монгол улсын хөгжлийн сан, бусад эх үүсвэрээр хийгдсэн хөрөнгө оруулалт, шинээр бий болсон ажлын байрны талаарх мэдээг нэгтгэн Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яаманд хүргүүлснээс эхний 3 улирлын байдлаар эрчим хүчний салбарт 144 байнгын ажлын байр, 966 түр ажлын байр бий болоод байна.

Хоёр. Бодлогын төлөвлөлт, түүний хэрэгжилтийг хангах чиглэлээр:

“100 000 нарны гэр” хөтөлбөрийн хүрээнд 9500 нарны цахилгаан үүсгүүрийг гүйцэтгэгчээс хүлээн авч 9420 нарны цахилгаан үүсгүүрийг бүх аймгаас төлбөрөө хийсэн малчин өрхөд нийлүүлээд байна. Нийт 20 аймгаас 10725 нарны цахилгаан үүсгүүрийн үнэд 2,252,250,000 төгрөг тусгай дансанд шилжсэн байна.

Монгол улсыг хөгжүүлэх сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх малчин өрхийг нарны цахилгаан үүсгүүрээр хангах “50 ваттын 8900 ширхэг нарны цахилгаан үүсгүүрийн иж бүрэн системийг нийлүүлэх” тендерийн Үнэлгээний хорооны шийдвэрийг цуцлуулах тухай “Бодь электроникс” ХХК-ийн нэхэмжлэлтэй хэргийг Захиргааны хэргийн шүүх хуралдаанаар хэлэлцсэнээс шүүхээс тус компанийн нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож шийдвэрлэв.

Түлш, эрчим хүчний салбарын өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын биелэлтийг 10 дугаар сарын 15-ны байдлаар гаргаж Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлснээс салбарын дүнгээр өвөлжилтийн бэлтгэл ажлын явц 93 хувийн биелэлттэй байна. Үйлдвэр компаниудын их засварын ажил хуваарийн дагуу явагдаж байна.

Станцуудын нүүрсний нөөцлөлтийг нэмэгдүүлэх талаар Төмөр замын удирдлагуудтай ярилцаж хэлэлцсэний дүнд 10 дугаар сарын 2-нд полувагонуудыг зөвхөн нүүрсэнд явуулах тухай Төмөр замын даргын холбогдох тушаал гарсан бөгөөд үүний дүнд төмөр замын вагон хангамж, нүүрсний тээвэрлэлт харьцангуй сайжирч, станцууд 5-22 хоногийн нүүрсний нөөцтэй болсон. Мөн нөөц нь багасаад байсан “ДЦС-3”, “ДЦС-4” ХК-уудын нөөцийг нэмэгдүүлж 58.0-160.0 мян.тн болгоод байна. Түүнчлэн “ДЦС-2”, “Дарханы ДЦС”, “Эрдэнэтийн ДЦС” ХК-уудын нөөцийг тус бүр 18.0-25.0 мян.тн-д хүргэхээр Төмөр замын удирдлагатай хамтран ажиллаж байна.

Түүнчлэн дулааны цахилгаан станц, нүүрсний уурхай, Улаанбаатар төмөр замын удирдлагуудын хамт 10 дугаар сарын нүүрс нийлүүлэлт, вагон хангамж, 11 дүгээр сард хэрхэн хамтран ажиллах талаар холбогдох уулзалтыг зохион байгуулж хамтарсан протокол гаргалаа.

Түлш, эрчим хүчний салбарын үйлдвэр, компаниудын ерөнхий инженерүүдийн 2007 оны ээлжит өргөтгөсөн шуурхай зөвлөлгөөнийг зохион байгуулан салбарын өвөлжилтийн бэлтгэл ажлыг хуваарьт хугацаанд нь дуусгах, үйлдвэрлэлийн хэвийн, найдвартай ажиллагааг хангах, ажлын хариуцлагыг дээшлүүлэх зорилгыг тус тус дэвшүүллээ. Түүнчлэн салбарыг хөгжүүлэхэд баримтлах бодлого, бүтээн байгуулалт хөрөнгө оруулалтын жилийн хүрээнд гүйцэтгэж буй ажлын явц, Төвийн эрчим хүчний системд 2006-2007 онд тогтоосон горимын хэрэгжилт, 2007-2008 оны өвлийн ачаалалд мөрдөн ажиллах горим, даалгаврыг тус тус хэлэлцэж, “Дорнод бүсийн эрчим хүчний систем” ХК, Адуунчулууны нүүрсний уурхайн үйл ажиллагаа, Сүхбаатар аймгийн Онгон-Дарьгангын 61 км урттай 15 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугамын барилга угсралтын ажлын явц байдалтай тус тус танилцан ажиллалаа.

“Түлш, эрчим хүчний салбарын норматив баримт бичгийн мэдээллийн бааз байгуулах хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд “Түлш, эрчим хүчний салбарын инженерүүдэд мэргэшлийн зэрэг олгох зөвлөлийн ажиллах дүрэм”, “Салбарын инженерүүдэд мэргэшлийн зэрэг олгох журам”-ын нэмэлт, өөрчлөлтийг Түлш, эрчим хүчний сайдын 2007 оны 9 дүгээр сарын 19-ний өдрийн 81 дүгээр тушаалаар баталлаа.

Эрчим хүчний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, үзэл баримтлалыг Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлэхээр бэлэн болгоод байна.

Түлш, эрчим хүчний сайдын 2007 оны 5 дугаар сарын 22-ны өдрийн 45 дугаар тушаалаар батлагдсан 2007 онд улсын төсвийн болон Монгол улсыг хөгжүүлэх сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг цаг алдалгүй, шуурхай зохицуулах, барилга угсралтын ажлын явцад хяналт тавих ажлын хэсгийг байгуулсан бөгөөд ажлын хэсгээс мэргэжил, арга зүйн удирдлагаар ханган батлагдсан хуваарийн дагуу /орон нутагт/ ажиллаж хяналт тавих арга хэмжээг авч байна.

Дорноговь аймгийн Хатанбулаг суманд 120 кВ-ын салхин цахилгаан станцын барилга угсралтын ажил дуусч захиалагчаас техникийн комисс ажиллуулж байна.

Улаанбаатар-Мандалговь-Оюутолгойн 220 кВ-ийн цахилгаан дамжуулах агаарын шугамын техник эдийн засгийн үндэслэлийг салбарын шинжлэх ухаан технологийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлж, зураг төслийг боловсруулж байна.

Чаргайтын усан цахилгаан станцын техник эдийн засгийн үндэслэлийг боловсруулах гүйцэтгэгчийг сонгон шалгаруулаад байна.

БНСУ-ын Ерөнхийлөгчийн Монгол улсад хийсэн айлчлалын үеэр Монгол улсын Түлш, эрчим хүчний сайд, БНСУ-ын Түлш, эрчим хүчний сайдын хооронд “Сэргээгдэх эрчим хүчний чиглэлээр хамтран ажиллах тухай” санамж бичигт гарын үсэг зурагдсаны дагуу Солонгос улсын Дэсонг групп, Түлш, эрчим хүчний яамны газрын дарга Ц.Сүхбаатар нар “Сэргээгдэх эрчим хүчний парк байгуулах тухай” санамж бичигт гарын үсэг зурсан. Үүний хүрээнд Дэсонг группийн төлөөлөгчидтэй холбогдох уулзалтыг зохион байгуулан ажилласан ба Солонгосын талаас боловсруулсан “Газар хөлслөх, хөлслүүлэх гэрээ”-тэй танилцан зохих өөрчлөлтүүдийг оруулж байна. Мөн “САТУ” ХХК-тай “Нөхөн сэргээгдэх эрчим хүчний парк барих” төслийн байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсэн үнэлгээ хийх ажлын гэрээ байгуулан ажиллаж байна. Түлш, эрчим хүчний яам Налайх дүүргийн ЗДТГ-ын хооронд хийгдэх газар эзэмшүүлэх гэрээний төсөл болон Түлш, эрчим хүчний яам Дэсонг группийн хооронд хийгдэх газар ашиглуулах гэрээний төслийг боловсруулан гарын үсэг зуралцсан бөгөөд уг гэрээг Түлш, эрчим хүчний сайдын зөвлөлийн хуралдаанд танилцуулахаар бэлтгэж байна.

Агаарын бохирдлыг бууруулах ажлын хүрээнд төвийн халаалтаас алслагдмал сургууль, цэцэрлэгт цахилгаан халаалтын тогоо суурилуулах, гэрт зориулсан цахилгаан халаагуур суурилуулах боломжтой холбогдсон судалгааг “Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” ХК, “Төвийн бүсийн цахилгаан дамжуулах сүлжээ” ХК-аар тус тус хийлгэн Улаанбаатар хотын захиргаанд хүргүүлээд байна.

Дарханы дулааны цахилгаан станцад турбогенератор шинээр суурилуулах “Эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх” хөтөлбөр төслийн зөвлөх шалгаруулах тендерийн ажлын эзлэхүүнд өөрчлөлт оруулан дахин зарлаж 10 дугаар сарын 29-ний өдөр нээснээс 5 компанийн дөрвийнх нь материал шаардлага хангасан бөгөөд тэдгээрийн бүрдлийг шалган судалж байна.

Улаанбаатар хотын дулаан-цахилгааны 5 дахь эх үүсвэрийг сонгох төсөл боловсруулах хүсэлт тавьсан Казакстан, Солонгос улсын холбогдох байгууллагын төлөөлөгчидтэй уулзан санал солилцоод байна.

Шивээ-Овоогийн уурхайг түшиглэн байгуулах уурхай, цахилгаан станц, цахилгаан экспортлох төслийн судалгааны ажлын талаар БНХАУ-ын цахилгаан сүлжээ компанийн зөвлөхтэй уулзаж санал солилцлоо.

Гурав. Эдийн засаг, хөрөнгө оруулалтын чиглэлээр:

Түлш, эрчим хүчний салбарт шинээр болон шилжин хэрэгжиж буй төслүүдийн санхүүжилтийн талаар шийдвэрлэх шаардлагатай асуудлуудыг төсөл хэрэгжүүлэгч байгууллага тус бүрээр боловсруулан ашиглах боломжгүй хөрөнгийг зохицуулах саналыг Засгийн газраар хэлэлцүүлснээр 2007 оны №209, №220, №226 дугаар тогтоолууд тус тус гарч энэ онд шинээр эхлэх буюу хэрэгжиж буй зарим төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийг шууд гэрээ байгуулан ажлыг эхлүүлж, батлагдсан хөрөнгийн эх үүсвэрт зохицуулалт хийж шийдвэрлэсний дагуу төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн гүйцэтгэлийг санхүүжүүлсэн. “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шууд гэрээ байгуулан хэрэгжүүлэх эрчим хүчний төсөл, арга хэмжээний жагсаалт батлах тухай” Засгийн газрын 2007 оны 220 дугаар тогтоолыг үндэслэн “Шууд гэрээ байгуулах тухай” Түлш, эрчим хүчний сайдын 2007 оны 9 дүгээр сарын 20-ны өдрийн 73 дугаар тушаал гарч гүйцэтгэчийг сонгон шалгаруулж гэрээг байгуулж дуусгаад байна.

Санхүүжилт 2007 оны эхний 10 сарын байдлаар:

1.1. Гадаад зээлийн дотоод эх үүсвэр:

Эрчим хүчний салбарт гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр дулааны цахилгаан станцуудыг шинэчлэх, орчин үеийн тоног төхөөрөмж, шаардлагатай сэлбэг, хэрэгслээр хангах, хөдөө орон нутгийн цахилгаан эрчим хүчний хангамжийг сайжруулахад чиглэсэн томоохон төсөл, арга хэмжээнүүдийг үргэлжлүүлэн амжилттай хэрэгжүүлж байна.

2007 онд гадаад зээлийн дотоод эх үүсвэрийг 1,097,0 сая төгрөгөөр санхүүжүүлэхээс 3 дугаар улирлын байдлаар 86,1 сая төгрөгийн дотоодын санхүүжилт хийгдсэн нь 7,2 хувьтай байна.

Дэлхийн банкны хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжиж буй “Цахилгаан шугам сүлжээний алдагдлыг бууруулах төсөл”-ийн ажил тендерийн үйл ажиллагаатай холбоотойгоор хугацаа алдсан учир хөрөнгийг бүрэн ашиглах боломжгүй болсон бөгөөд 2007 оны 8 дугаар сарын 22-ний өдрийн

Засгийн газрын №209 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар зохицуулсан шийдвэрийн дагуу 555,0 сая төгрөгийг хасч зохицууллаа.

1.2.Цахилгаан дамжуулах агаарын шугам:

2007 онд өндөр хүчдэлийн цахилгаан дамжуулах агаарын шугамаар нийт 79 сумын төвийг холбох ажлын явц 70 орчим хувьтай буюу нийт санхүүжилт 44,245,5 сая төгрөг байна.

1.3. Дулааны цахилгаан станц:

Дулааны станцуудын засвар, шинэчлэлтийн ажилд 2007 онд нийт 3,950,0 сая төгрөгийн хөрөнгө тусгагдсанаас 1,289,0 сая төгрөгийг санхүүжүүлээд байна. Үүнд: Дарханы дулааны цахилгаан станцаас Дархан хот хүртэлх дулааны магистраль шугамын шинэчлэлтийн ажлын 608,4 сая төгрөг, Налайхын дулааны станцын 3 зуухны конвективын багц хоолойг солих, насос шинэчлэх ажилд 269,7 сая төгрөг, Төв аймгийн Зуунмод сумын гадна дулааны шугамын шинэчлэлтийн ажилд 410,9 сая төгрөгийн санхүүжилт хийснээр 37,4 хувьтай байна.

1.4.Сэргээгдэх эрчим хүч:

Нар, салхи, дизель хосолсон сэргээгдэх эрчим хүчээр нийт 16 сумын төвийг цахилгаан эрчим хүчээр хангахаар 23,649,3 сая төгрөг төлөвлөсөнөөс 3 дугаар улирлын байдлаар 11,816,0 сая төгрөгийн санхүүжилтийг хийгээд байна. Үүнээс: 2007 оны эхний 10 сарын байдлаар Дорноговь аймгийн Мандах сумын 80 кВ-ын хүчин чадалтай салхин цахилгаан станцыг ашиглалтад хүлээлгэн өгөөд хэвийн ажиллаж байна.

2007 оны 8 дугаар сарын 22-ний өдрийн Засгийн газрын №209 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар “100 000 нарны гэр” хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай нийт 9,771,0 сая төгрөгийн хөрөнгийг зохицуулан шийдвэрлэсний дагуу эхний 10 сарын байдлаар 10000 нарны цахилгаан үүсгүүрийн үнд нийт 6,081,0 сая төгрөгийг санхүүжүүлээд байна.

Малчин өрхийг нарны цахилгаан үүсгүүрээр хангах “100 000 нарны гэр” үндэсний хөтөлбөрийн хүрээнд малчдаас төвлөрүүлж буй нарны цахилгаан үүсгүүрийн төлбөрийг “ХААН” банкны шаталсан тусгай хадгаламжийн дансанд байршуулж уг дансны тогтмол үлдэгдэлд хүү тооцуулах санал болон “Байгууллагын шаталсан тусгай харилцах, хадгаламжийн дансны үйлчилгээний гэрээ”-ний төслийг боловсруулаад байна.

1.5. Түлшний салбар:

2007 онд түлшний салбарт хийн баллоныг шалгах, баталгаажуулах, туршиж тохируулах төв болон шинжилгээний лабораторийг байгуулах, нүүрснээс газрын тосны бүтээгдэхүүн гаргах нүүрсний ордуудын судалгаа явуулах, сонголт хийх, утаагүй түлшний үйлдвэрлэлийн техник эдийн засгийн үндэслэл, зураг төсөв боловсруулах, нүүрсний хийн технологийн судалгааны лаборатори байгуулах зэрэг ажлуудад нийт 1,070 сая төгрөгийн хөрөнгө батлагдсанаас 97,7 сая төгрөгийн санхүүжилт хийгдээд байна.

2007 онд гадаад орон, олон улсын байгууллагын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж буй төслүүдийн ашиглалтын мэдээг 2007 оны 10 дугаар сарын 1-ны байдлаар нэгтгэж гаргалаа.

Төсөл хэрэгжүүлэгч нэгжүүдийн үйл ажиллагааны зардлын төсвийн дагуу 2007 оны 10 дугаар сард 222,3 сая төгрөгийн санхүүжилтийг хийлгэж 99,1 сая төгрөгийн гүйцэтгэлийг хүргүүлээд байна. 2007 оны 10 дугаар сарын байдлаар нийт зээлийн 7 төсөл, тусламжийн 5 төслөөр 17,08 сая ам.долларын гүйцэтгэлийг санхүүжүүлээд байна.

Сангийн сайдын 2007 оны 5 дугаар сарын 7-ны өдрийн 120 дугаар тушаалаар баталсан “Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгөөр санхүүжигдэх төслийг хэрэгжүүлэхэд баримтлах журам”-ын дагуу гадаад орон, олон улсын байгууллагын зээлийн хөрөнгөөр хэрэгжиж буй төслүүдийн төсөл хэрэгжүүлэгч нэгжид ажиллагсдын цалинг “Төслийн нэгжийн ажилтнуудын цалингийн дээд хэмжээг тогтоох аргачлал”-ын дагуу тооцон нэмэгдүүлж 2007 оны цалингийн сан болон үйл ажиллагааны зардалд нийт 0,5 тэрбум төгрөгийн эх үүсвэрийг шийдвэрлүүлээ.

Абу-Даби сан, Кувейтийн сан болон Монголын талын уулзалтын шийдвэрийн дагуу Кувейтийн сангийн зээлийн хөрөнгийн санхүүжилтийн хуваарийг шинэчлэн боловсруулж, барилга угсралтын гүйцэтгэлийг санхүүжүүлэх үлдэгдэл болох 2,45 сая ам.долларын хөрөнгийн санхүүжилтийн талаарх саналыг боловсруулж Сангийн яаманд хүргүүлээ.

Үйл ажиллагааны алдагдлын санхүүжилт авдаг Завхан, Говь-Алтай аймгийн эрчим хүчний үйлдвэр, “Баруун бүсийн эрчим хүчний систем” ХК, Налайхын дулааны станцад 2007 оны 10 дугаар сарын хуваарьт санхүүжилт болох 844,05 сая төгрөгийг олгуулав.

Зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж буй төслүүдийн гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас хуулийн дагуу чөлөөлүүлэх 2 асуудлыг судлан холбогдох журмын дагуу Сангийн яаманд уламжлан шийдвэрлүүлээ.

Монгол улсын эдийн засаг, нийгмийг 2006-2008 онд хөгжүүлэх Үндсэн чиглэлийн хүрээнд Түлш, эрчим хүчний салбарыг 2008 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн төслийг 2008 оны төсвийн хүрээний мэдэгдэлтэй уялдуудан боловсруулж 8 дугаар сарын 2-ны өдрийн а/1420 тоотой Сангийн яаманд хүргүүлж улмаар Улсын Их Хуралд оруулахад шаардлагатай танилцуулга, тайлбар, үндэслэлээр ханган ажиллалаа.

Засгийн газраас Монгол улсын 2008 оны нэгдсэн төсвийн төсөл, Монгол улсын эдийн засаг, нийгмийг 2008 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг Улсын Их Хуралд өргөн барихтай холбогдуулан “Монгол улсын эдийн засаг, нийгмийг 2007 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”-ийн хэрэгжээгүй зорилт арга, хэмжээ, бусад үйл ажиллагааг 2008 оны төсвийн төсөл, үндсэн чиглэлд тусгуулах саналыг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлээ.

Монгол улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийг түргэтгэх, улсын төсөв болон гадаадын зээл, тусламжийн үр ашгийг дээшлүүлэх, салбаруудын улсын төсөвт оруулах орлогын хэмжээг нэмэгдүүлэх, барилга байгууламжийг барихад аж ахуйн нэгж байгууллагын оролцоог эрчимжүүлэх, ойрын ирээдүйд баримтлах хөрөнгө оруулалтын бодлого, стратегийг тодорхойлох зорилгоор Сангийн сайдын 2007 оны 9 дүгээр сарын 17-ны өдрийн №250 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсэгт ажиллан хөрөнгө оруулалтын өнөөгийн байдлыг судалсан судалгаа, гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж дууссан болон хэрэгжиж буй төслүүдийн судалгаа, зээлийн эргэн төлөлтийн талаарх судалгаануудыг тус тус хийж баталсан төлөвлөгөөний дагуу ажиллаж байна.

Сангийн яамны Өрийн удирдлагын хэлтэстэй хамтран салбарт гадаад орон, олон улсын байгууллагын зээлийн хөрөнгөөр хэрэгжиж буй төслүүдийн хэрэгжилтийн явцын тайлантай танилцаж, тулгамдсан асуудлуудын талаар зөвлөлдөн төслийн хэрэгжилтийг удаашруулж буй нөхцөл шалтгааны талаар Сангийн яаманд холбогдох танилцуулгыг хүргүүлээ.

Ерөнхий сайдын 2007 оны 6 дугаар сарын 26-ны өдрийн №60 дугаар захирамжаар 2007 онд Улаанбаатар хот болон орон нутгийн хөрөнгөөр баригдаж буй зам гүүрийн барилгын ажлын талбайд орсон цахилгааны шугамыг шилжүүлэх ажлыг “Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” ХК-аар гүйцэтгүүлж, хөрөнгийн асуудлыг шийдвэрлэх арга хэмжээ авахыг Зам, тээвэр, аялал жуулчлалын сайд, Түлш, эрчим хүчний сайд, Төрийн өмчийн хорооны дарга нарт даалгасны дагуу “Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” ХК-аас зам гүүрийн барилгын ажлын талбайд орсон цахилгаан шугам сүлжээг зайлуулахад шаардлагатай 256,6 сая төгрөгийг асуудлыг Засгийн газрын хуралдаанаар шийдвэрлүүлэхээр тогтоолын төсөл, танилцуулгыг бэлтгэж яамдаас санал авахаар хүргүүлээд байна.

Түлш, эрчим хүчний дэд сайд болон газар хэлтсийн дарга нар Шарын голын уурхайн удирдлагатай 2007 оны 9 дүгээр сарын 10-нд хийсэн уулзалтаар энэ оны 11, 12 дугаар сард нүүрсний үнэ нэмэгдүүлэх тухай асуудлыг дахин судлаж үзэхээр тохиролцсноор Шарын голын уурхайгаас Дархан, Эрдэнэтийн дулааны цахилгаан станцуудад нүүрс нийлүүлсэн билээ. Уг асуудлын дагуу тус уурхайн удирдлагаас 2007 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн №03 албан тоотой нүүрсний үнэ нэмэгдүүлж өгөх тухай хүсэлтээ дахин ирүүлснийг судлан үзэж Түлш, эрчим хүчний сайдын зөвлөлийн хуралдаанд танилцуулахаар бэлтгэж байна.

Дөрөв. Гадаад харилцаа, хамтын ажиллагааны чиглэлээр:

Гадаад хэргийн яаманд Монгол улсын Ерөнхийлөгчийн 2007 оны 11 дүгээр сарын сүүлчээр Кувейт улсад хийх албан ёсны айлчлалын ярианы сэдэвт түлш, эрчим хүчний хамтын ажиллагааны хүрээнд хөдөө орон нутгийг сэргээгдэх эрчим хүч ашиглан хямд, алдагдал багатай, байгаль орчинд хор нөлөөгүй цахилгаанжуулах, фермер, мал аж ахуйг хөгжүүлж усжуулах, хот суурин газрын агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр хамтран ажиллах, Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станцыг барьж байгуулахад тусалцаа үзүүлэх зэрэг асуудлыг тусгуулах тухай саналыг хүргүүлээд байна.

БН Турк улсын Эрчим хүч, эрдэс баялгийн яам, тус улсад суугаа Монгол улсын онц бөгөөд бүрэн эрхт элчин сайд нарт усан цахилгаан станцын мэргэжил дээшлүүлэх сургалтанд Монголын мэргэжилтнүүдийг хамруулах тухай албан бичгийг хүргүүлээд байна.

Түүнчлэн гадаад харилцаа, хамтын ажиллагааны чиглэлээр холбогдох бусад уулзалт, ярилцлагыг зохион байгуулж тулгамдсан асуудлуудын талаар тодорхой санал, хамтын ажиллагааны төлөвлөгөө боловсруулан, гарсан үр дүнгийн биелэлтэд хяналт тавин хамтран ажиллалаа.

Тав. Хяналт шинжилгээ, үнэлгээний чиглэлээр:

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтийн явцад хяналт шинжилгээ хийлээ. Дээрх төлөвлөгөөнд Түлш, эрчим хүчний сайдын эрхлэх асуудлын хүрээнд тусгагдсан 74 арга хэмжээний хэрэгжилт 2007 оны III улирлын байдлаар 87,7 хувьтай байна. Хяналт шинжилгээний дүнгээс үзэхэд Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд ТЭХ-ний сайд дангаар буюу толгойлж хэрэгжүүлэхээр тусгагдсан: *Баруун-Урт-Өндөрхааны 110 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, Хөвсгөлийн Чаргайт, Эгийн голын усан цахилгаан станцыг барих, Өвөрхангайн Баянтээг, Увсын Хартарвагатайн нүүрсний ордыг түшиглэн цахилгаан станц барих, “100000 нарны гэр” Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх, Тавантолгойн цахилгаан станц, Улаанбаатар-Мандалговь-Оюутолгойн 220 кВ-ын цахилгаан дамжуулах хос шугам, дэд станцын техник эдийн засгийн үндэслэл боловсруулах* зэрэг арга хэмжээний хэрэгжилт удаашралтай байна.

Түлш, эрчим хүчний яаманд байгууллага, иргэдээс ирүүлсэн албан бичиг, өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн байдалд хяналт шинжилгээ хийснээс иргэн, байгуулагаас ирүүлсэн албан бичиг, өргөдөл гомдлын шийдвэрлэлт 94,0 хувьтай, салбарын үйлдвэр, компаниудаас ирүүлсэн өргөдөл гомдлын шийдвэрлэлт 57,0 хувьтай байна.

Зургаа. Мэдээ, мэдээлэл, мэдээллийн технологийн чиглэлээр:

Түлш, эрчим хүчний салбарын 85 жилийн ойг угтсан салбарын үйл ажиллагааг олон нийтэд мэдээлэх ажлын хүрээнд салбарын холбогдолтой мэдээ, мэдээллүүдийг үндэсний өдөр тутмын мэдээллийн хэрэгслэлүүдээр тухай бүр хүргэж ажиллалаа.

Түлш, эрчим хүчний салбарын байгууллагуудын үйл ажиллагааны мэдээг нэгтгэн гаргаж удирдлагыг шуурхай мэдээллээр хангаж ажиллалаа.

Засгийн газрын гишүүд орон нутагт ажиллахтай холбогдуулан тухайн орон нутгийн түлш, эрчим хүчний хангамжийн талаарх танилцуулгыг бэлтгэж хүргүүлжээ. Түүнчлэн бусад байгууллагыг салбарын холбогдолтой шаардлагатай мэдээ, танилцуулгаар тухай бүр ханган ажиллалаа.

Яамны дотоод, гадаад сүлжээний гэмтэл, техник тоног төхөөрөмжийн хэвийн үйл ажиллагааг ханган ажиллаж, гэмтэл саатлыг тухай бүр нь арилгаж ажиллалаа.

Хүнс, хөдөө аж ахуйн салбарт:

Гадаад бодлогын чиглэлээр:

Батлан хамгаалах салбарт:

ОХУ-ын Ерөнхийлөгч В.Путин бүрэн эрхийнхээ хугацааг дууссаны дараа улс төрийн тавцангаас хөндийрөхгүй нь тодорхой байна. Түүнийг Орост парламентын засаглалыг бэхжүүлэх бодолтой байгаа гэж шинжээчид үзэж байгаа аж. В.Путин, Оросын төр засгийн чухал албан тушаалд өөрийн итгэлийг хүлээсэн хүмүүсийг томилсоор байна.

В.Путин, энэ оны 12 дугаар сарын 02-нд болох Төрийн Думын сонгуульд “Нэгдсэн Орос” намаас нэр дэвших саналыг хүлээж авснаа мэдэгдсэн байна. Тэрээр тус намыг сонгуульд ялбал Засгийн газрын тэргүүнээр ажиллаж болохыг үгүйсгэсэнгүй.

ОХУ-ын Ерөнхийлөгчийн зарлигаар ТУХН-ийн гүйцэтгэх нарийн бичгийн дарга В.Рушайлог ажлаас нь чөлөөлсөн бөгөөд түүний оронд нь Гадаад тагнуулын албаны

дарга С.Лебедевийг томилсон байна. Гадаад тагнуулын албаны даргын албан тушаалд Ерөнхий сайд асан М.Фрадковийг томилжээ.

ТУХН-ийн гишүүн орнууд цэрэг, эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлэх, терроризмын эсрэг хүчний байгууллагуудын харилцан ажиллагааг бэхжүүлэх, агаарын довтолгооноос хамгаалах хүрээнд Хамтын аюулгүй байдлын гэрээний байгууллагын оролцоо, үүргийг нэмэгдүүлэхэд анхаарч байна.

Киргизийн нийслэл Бишкек хотод 11 дүгээр сарын 28-нд Хамтын аюулгүй байдлын гэрээний байгууллага (ХАБГБ)-ын орнууд (ОХУ, Казахстан, Тажикистан, Беларусс, Армени, Киргиз, Узбекистан)-ын Батлан хамгаалахын сайд нарын зөвлөл болон Аюулгүй байдлын зөвлөлийн дарга нарын хорооны хуралдаан тус тус болсон байна. ХАБГБ-ын орнуудын Батлан хамгаалахын сайд нарын зөвлөлийн хуралдаанаар тус байгууллагын гишүүн орнуудад цэргийн түрэмгийлэл, зэвсгийн хүчээр заналхийлсэн тохиолдолд цэрэг-техникийн тусламж үзүүлэх тухай багц баримт бичгийг боловсруулж, цэрэг-эдийн засгийн харилцааг өргөжүүлэх асуудлаар санал солилцжээ.

Хуралдааны үед Беларуссын Батлан хамгаалахын сайд Л.Мальцев мэдэгдэл хийхдээ, "...Польш улс ПДХС-ийн бүрэлдэхүүн хэсгүүдийг өөрийн нутаг дэвсгэрт байрлуулснаар пуужингийн довтолгооноос өөрийгөө хамгаалах бус харин түрүүлж нэрвэгдэх аюултай" гэж анхааруулсан байна. Тэрээр, "...Европт хүчний тэнцвэрийг алдагдуулснаар урьдчилан тааж боломгүй нөхцөл байдал үүснэ. Ялангуяа ПДХС-ийг нутагтаа байрлуулсан орнуудад илүү аюул занал учирна гэдгийг ойлгох хэрэгтэй" хэмээн мэдэгдсэн байна.

Москва, зүүн Европт пуужингийн довтолгооноос хамгаалах систем байгуулах Вашингтоны бодлогын эсрэг зохих арга хэмжээ авсаар байна.

Оросын тал, Вашингтон ПДХС-ийн асуудлаар буулт хийж, Москвагийн саналыг хүлээж авах боломж бий гэж үзсээр байна. Харин АНУ, стратегийн зэвсэглэлийн салбарт итгэлцлийг бий болгох талаар Оростой яриа хэлэлцээ хийхийг эрмэлзэж байгаа нь улам даамжрах төлөвтэй болсон зэвсэглэлээр хөөцөлдөх хандлагыг саармагжуулахад чиглэж байна.

ОХУ-д, шинэ үеийн РЛС-үүдийг байрлуулах ажил идэвхитэй хийгдэж, Оросын Сансрын цэргийн командлагч, хурандаа генерал В.Поповкины мэдээлснээр, Армавирын "Воронеж-ДМ" радиолокацийн станцыг 2007 оны сүүлчээр байлдааны жижүүрлэлтэд туршилтын журмаар гаргахаар бэлтгэж байна.

ОХУ-ын Төрийн Дум Польш, Чехийн парламентад хандаж, ПДХС-ийн асуудлаар хамтарсан бага хурал хийх саналыг дэвшүүлсэн байна. Саналд, ПДХС-ийг өөрийн нутагт байрлуулснаар Дорнод Европын орнуудын аюулгүй байдал баталгаагүй болох эрсдэл байгааг анхааруулжээ.

Орос-Америкийн Гадаад хэргийн болон Батлан хамгаалахын сайд нарын уулзалт Москвад боллоо. Оросын Гадаад хэргийн сайд С.Лавров, АНУ-ын Төрийн нарийн бичгийн дарга К.Райстай уулзаж, ПДХС-ийн асуудлаар хэлэлцээ хийсэн боловч тохиролцоонд хүрээгүй байна. АНУ-ын Батлан хамгаалахын сайд Р.Гейтс, ОХУ-ын Батлан хамгаалахын сайд А.Сердюковтой уулзахдаа Сири, Иранд зэвсэг худалдаж буйд Москвад сэтгэл дундуур байгаагаа илэрхийлж, "Европ дахь ердийн Зэвсэгт хүчний тухай гэрээ"-г шинэчлэх талаар Вашингтоны боловсруулсан хувилбарыг танилцуулсан боловч Оросын тал хүлээж аваагүй байна. Уулзалтын дараа Р.Гейтс Оросын ЗХЖШ-ын Академид зочлох үедээ "...Вашингтон ямар ч тохиолдолд Гүрж, Украинд цэргийн бааз байгуулахгүй" гэж мэдэгджээ. АНУ-ын төлөөлөгчид 10 дугаар сарын 12-нд Ерөнхийлөгч В.Путинд бараалхсан бөгөөд В.Путин ойрын болон дунд зайн пуужинг устгах талаар хоёр тал олон улсыг хамарсан гэрээ хэлэлцээр байгуулах шаардлагатай байгаа тухай ярьсан байна. Тэрээр "...Энэ чиглэлээр зөвхөн ОХУ, АНУ хоёр хэлэлцээр байгуулсан. Гэтэл бусад улс энэ гэрээнд нэгдээгүйгээс стратегийн зэвсэглэлээ хөгжүүлсээр байна. Тиймээс бусад улсыг гэрээнд нэгдэхийг уриалах хэрэгтэй. Бид батлан хамгаалах асуудлаар хоёр талын яриа хэлэлцээг цаашид үргэлжлүүлэх сонирхолтой байна" гэж мэдэгджээ.

Европ дахь ОХУ-ын гол түнш гэгддэг Герман ПДХС, “Европ дахь ердийн Зэвсэгт хүчний тухай гэрээ”-ний асуудлаар Москвагийн бус АНУ-ын байр суурийг дэмжих хандлагатай байна. Ерөнхийлөгч В.Путин 10 дугаар сарын 14-нд Германд айлчлал хийлээ. Тэрээр Висбаден хотод Германы канцлер А.Меркельтэй хоёр орны Засгийн газрын гишүүдийг оролцуулсан улс төр-эдийн засгийн харилцаа, АНУ-ын ПДХС, Ираны цөмийн хөтөлбөр, Европ дахь ердийн Зэвсэгт хүчний тухай гэрээ, олон улсын эрчим хүчний аюулгүй байдал, дэлхийн халуун цэгүүдийн асуудлаар өргөтгөсөн зөвлөлгөөн хийсэн байна. Хэлэлцээний үед талууд шинжлэх ухаан, техник, эдийн засгийн салбарт хамтын ажиллагааг хөгжүүлэх хэд хэдэн хэлэлцээрт гарын үсэг зурсан боловч олон улсын зарим асуудлаар байр сууриа нэгтгэж чадсангүй. Германы тал, Косово болон Ираны асуудлаар баримтлаж буй хатуу байр сууриа өөрчлөхгүй, ПДХС-ийн асуудлаар Оросын байр суурийг дэмжихгүй гэдэг нь хэлэлцээний үед тодорхой болжээ.

ХКН, ээлжит их хурлаараа 2012 он хүртэлх хөгжлийн хөтөлбөрийг тодорхойлж нам, төрийн удирдах бүрэлдэхүүнийг сонголоо.

ХКН-ын XVII Их хурал 10 дугаар сарын 21-нд өндөрлөлөө. ХКН-ын Төв Хорооны анхдугаар бүгд хурал 10 дугаар сарын 22-нд болж, Намын Төв Хорооны 17 дахь удаагийн сонгуулийн 1 дүгээр бүгд хурлаар Намын Төв Хорооны Ерөнхий нарийн бичгийн дарга, БНХАУ-ын дарга Ху Жиньтаог БНХАУ-ын Цэргийн Төв Зөвлөлийн даргын албан тушаалд улируулан сонгожээ. Үүний сацуу Намын Төв Хорооны Цэргийн Төв Зөвлөл, Сахилга батыг хянан шалгах комиссийн дарга, орлогч дарга, гишүүдийг сонгосон байна. Намын Төв Хорооны Улс төрийн товчооны Байнгын хорооны бүрэлдэхүүнд Хятад улсын дарга Ху Жиньтао, БХАТИХ-ын Байнгын хорооны дарга У Бангуо, Төрийн Зөвлөлийн Ерөнхий сайд Вэнь Зябао, байнгын хорооны гишүүн Зя Цинлинь, Ли Чанчунь нар хэвээр үлдэж, Шанхай хотын намын хорооны дарга Си Зиньпин, Ляонин мужийн намын хорооны дарга Ли Кэцянь, Намын Төв Хорооны намын зохион байгуулалтын хэлтсийн дарга Хэ Гуоцянь, Нийгмийг аюулаас хамгаалахын сайд Жоу Юнкан нар шинээр сонгогдсон байна. Зэн Цинхун, У Гуаньжэн, Луо Ган нар Улс төрийн товчооны Байнгын Хорооны гишүүнээс огцорчээ.

Хятадын удирдлага, Японтой харилцаагаа сайжруулахад анхаарлаа хандуулж байна. Тухайлбал Бээжин, Японд ажиллаж байсан элчин сайдыг Хятадын Гадаад хэргийн орлогч сайдаар томилсон нь Токиотой харилцахад түлхүү анхаарч буйн шинж гэж болно.

Хятадын Төрийн зөвлөлийн Ерөнхий сайд Вэнь Зябао 9 дүгээр сарын 27-нд Хятад-Японы хоорондын дипломат харилцаа тогтоосны 35 жилийн ойн арга хэмжээнд оролцохоор Бээжинд очсон Японы төлөөлөгчдийг хүлээн авч уулзаж, хоёр улсын харилцаа сүүлийн үед тогтворжих хандлагатай болсныг онцлон тэмдэглээд 2008 онд БНХАУ-ын дарга Ху Жиньтаог Японд айлчлуулах талаар мэдэгдсэн байна. Саяхан Хятадын Төрийн зөвлөлийн шийдвэрээр, БНХАУ-аас Японд сууж байсан Элчин сайд Ван И-г ГХЯ-ны орлогч сайдын албан тушаалд томилжээ.

Умард, өмнөд Солонгосын харилцааны түүхэнд удирдагчдын хоёр дахь удаагийн дээд хэмжээний уулзалт (үүний өмнө 2000 онд, өмнөд Солонгосын Ерөнхийлөгч Ким Дэ Жун Пхеньянд айлчилж байсан) Пхеньянд болж, 50 гаруй жилийн туршид дайсагналцсан байдалд байгаа хоёр талын харилцаанд нааштай өөрчлөлтүүд гарч, Солонгосын хойгт байдал тогтворжих цаг холгүй байгааг нотлов.

Өмнөд Солонгосын Ерөнхийлөгч Но Му Хён хоёр талын хилийг тодорхойлогч “шар шугам”-ыг явган нэвтэрч, Пхеньянд хийсэн айлчлалын гол зорилго нь энхийн гэрээ байгуулах явдал хэмээн мэдэгдсэн, хоёр тал түүнчлэн энх тайвныг тогтооход чиглэсэн баримт бичигт гарын үсэг зурсан зэрэг нь хоёр Солонгосын харилцааны цоо шинэ үед шилжин орлоо гэж үзэхээр байна. Умард Солонгост 10 дугаар сарын 02-04-нд айлчилсан Но Му Хён хилийн дээсийг давсан даруйдаа “...бид эдийн засгийн хамтын ажиллагааны салбарт ихээхэн ахицтай байгаа хэдий ч саад бэрхшээл тулгарсаар байна. Үүний шалтгаан нь олон улсын хүчин зүйл төдийгүй умард, өмнөд талуудын санал зөрөлдөөн юм. Манай улсыг хагас зуу гаруй жилийн турш хуваагдмал байлгасан энэ хана хэрэм удахгүй нуран унана гэдэгт итгэлтэй байна...Энэ удаагийн уулзалтын зорилго бол бүх салбарт, түүний дотор цэргийн салбарт хамтын ажиллагааг бэхжүүлэхэд чиглэгдэж байна” хэмээн онцлон тэмдэглэсэн байна.

Хоёр Солонгосын тэргүүн нар 10 дугаар сарын 03-нд, Солонгосын хойгт энх тайвныг тогтоох, эдийн засгийн хамтын ажиллагааг хөгжүүлэх асуудлаар 2 удаа хэлэлцээ хийж, энэ талаарх хамтарсан тунхаг бичигт 10 дугаар сарын 04-нд гарын үсэг зурсан байна. Солонгосын хойгийн баруун хэсэгт буюу Шар тэнгисийн районд “энх тайвны бүс” байгуулах тухай тусгасан энэ баримт бичиг нь 1950-53

оны дайны дараа НҮБ-аас тогтоож өгсөн, “Умард зааглах шугам” хэмээн нэрлэгддэг районд зэвсэгт мөргөлдөөн гаргахгүй байхад чиглэжээ.

Умард Солонгосын цөмийн хөтөлбөрийг зогсоох асуудалд ахицтай алхмууд хийгдсээр байна.

Бээжин хотноо болсон 6 талын хэлэлцээний төгсгөлд гаргасан нэгдсэн баримт бичигт, Ёнбен дахь цөмийн байгууламжийн 3 реакторыг энэ онд багтааж ажиллагаагүй болгох, цөмийн хөтөлбөрийг зогсоох, энэ хөтөлбөрийн хүрээнд ашиглаж байсан материал, техник, технологийг бусдад шилжүүлэхгүй байх талаар тусгажээ.

АНУ, Их Британи хоёр цэргээ гаргах арга хэмжээ авах тухай мэдэгдэж, Иракийн Ерөнхий сайд Н.Малики, Ираны Ерөнхийлөгч М.Ахмадинежад нар аюулгүй байдлын салбарт хамтран ажиллах тухай зөвшилцөлд гарын үсэг зурсан нь Иракийн байдал тогтворжиж эхлэх нэг үндэс болж байна.

Өнгөрөгч 8 дугаар сараас хойш шийтийн босогчдын зүгээс явуулж буй зэвсэгт халдлагын тоо буурч байна. Өнгөрөгч 9 дүгээр сард америкийн 62 цэрэг Иракт амь үрэгдсэн нь 2006 оны 6 дугаар сараас хойш анх удаа амьд хүчний хохирол хамгийн бага амссан сар боллоо. Мөн энэ удаагийн Рамадан баярын үед үйлдэгдсэн зэвсэгт халдлагын тоо ч өмнөх оныхтой харьцуулбал 40 хувиар буурсан байна.

Америкийн тал Иракаас цэргээ хэсэгчлэн гаргаж эхэлсний сацуу Их Британий тал ч цэргээ гаргахаар бэлтгэж байна. Америкийн тэнгисийн явган цэргийн 2,2 мянган албан хаагч Иракаас гарсан бол ХЗЦ-ийн 4 мянган цэрэг ирэх 12 дугаар сарын дундуур, мөн явган цэргийн 4 бригад, тэнгисийн явган цэргийн 2 батальоныг 2008 оны 6 дугаар сараас өмнө гаргахаар төлөвлөж байна. Эдгээр цэргүүд нь Иракт үүрэг гүйцэтгэж байгаа үндсэн хүчийг бэхжүүлэхээр энэ онд очсон 30 мянган хүнтэй хүчний бүрэлдэхүүнд багтаж байгаа юм. Харин Америкийн 130 мянган хүний бүрэлдэхүүнтэй үндсэн хүч Иракаас хэзээ гарах нь тодорхойгүй, энэ асуудлаар Цагаан ордон, Конгрессын хооронд санал зөрөлдсөн хэвээр байгаа төдийгүй Ирак, Афганистанд явуулж буй цэргийн ажиллагааны зардал жил тутам нэмэгдсээр байна.

АНУ-ын Сенат, 10 дугаар сарын 03-нд болсон хуралдаанаар тус улсын цэргийг 2008 оны 6 дугаар сарын 31-нээс өмнө Иракаас гаргах тухай Ардчилсан намын шаардлагыг хүлээж авахаас татгалзсан байна.

Турк улсын парламент, өөрийн зэвсэгт хүчинд хөрш Иракийн нутагт курдын салан тусгаарлагчдын эсрэг байлдааны ажиллагаа явуулах зөвшөөрлийг олголоо. Туркийн тусгай томилолтын цэрэг 10 дугаар сарын 24-нд Иракийн нутаг дэвсгэрт цөмрөн орлоо. Тус улсын цэрэг Иракийн хойд хэсэгт Курдистаны Ажилчны намын (КАН) зэвсэгт бүлэглэлүүдийг бүслэж артиллери, байлдааны нисдэг тэрэг, “F-16” сөнөөгч онгоцоор цохилт өгч байна.

Турк энэ талаар “...бид ажиллагаа явуулах гэж байгаагаа АНУ-ын талд мэдээлсэн. Америкийн холбогдох албадтай тагнуулын мэдээлэл солилцож байгаа” гэж мэдэгдсэн нь бусад эх булгаар хараахан батлагдаагүй байна.

Хоёр. Яамны үйл ажиллагааны талаар

2.1. Стратегийн удирдлага, төлөвлөлтийн чиглэлээр

“Афганистаны үндэсний армийг хөгжүүлэх хөтөлбөр”-ийн хүрээнд үүрэг гүйцэтгэх Сургалтын хөдөлгөөнт багийн наймдугаар ээлжийг илгээх тухай” асуудлыг Засгийн газрын 2007 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн 265 дугаар тогтоолоор баталгаажууллаа.

“Агаарын зайг нисэхэд ашиглах ерөнхий журам”-ын төслийг ЗТАЖЯ-тай хамтран боловсруулж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн.

“2008 онд Зэвсэгт хүчний 123 дугаар ангитай дайчилгаатай, байлдааны буудлагатай команд-штабын хээрийн сургуулийг явуулах тухай” асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлсэн.

“Их сургууль, коллежид суралцагчдад сургалтын төлбөрийн зээл, буцалтгүй тусламж олгох, эргэж төлүүлэх журам”-д нэмэлт оруулах тухай Засгийн газрын тогтоолын төсөл боловсруулж холбогдох байгууллагад хүргүүлэв.

“Иргэн цэргийн албыг дүйцүүлэн хаах журам”-ын төслүүдийн эхний хувилбарыг боловсруулж, хэлэлцүүлэг зохион байгуулан оролцогсдын саналуудыг төсөлд тусган нэгтгэж байна.

“Батлан хамгаалах судлал” сэтгүүлийн ээлжит дугаарын материалыг бэлтгэн боловсруулж, хэвлэлтэнд хүргүүлсэн.

Дайчилгааны хуулийн холбогдох заалт болон Батлан хамгаалахын сайдын аймаг, нийслэлийн Засаг дарга нартай байгуулсан бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээг үндэслэн аймаг, нийслэлийн Засаг даргын орлогч нартай цэрэг-стратегийн бэлтгэл сургалт явуулах тухай Батлан хамгаалахын сайдын тушаал гарч 2007 оны 10 дугаар сарын 30-наас 11 дүгээр сарын 2-ны өдрүүдэд зохион байгуулагдахаар бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.

Мөн аймаг, нийслэлийн цэргийн штабын дарга нартай явуулах цугларалт явуулах төлөвлөгөө, хөтөлбөрийг боловсруулан бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.

Бүгд найрамдах Солонгос Улсын батлан хамгаалахын сайдын урилгаар Монгол Улсын УИХ, ЗГ-ын гишүүн Батлан хамгаалахын сайд М.Сономпил 2007 оны 10 дугаар сарын 14-19-ний өдрүүдэд албан ёсны айлчлал хийлээ.

Айлчлалын үеэр БНСУ-ын Сөүл хотод зохион байгуулагдсан цэргийн “Сөүл Агаарын шоу-2007” арга хэмжээнд оролцлоо. Энэ арга хэмжээнд нийт 40 орны төлөөлөгчид оролцсноос 26 орны төлөөлөгчид өөрийн орны шинэ зэвсэглэл техникийн үзэсгэлэнг гаргаж толилуулсан байна.

Зэвсэгт хүчний Жанжин штабын даргын даргын ОХУ-д хийх айлчлалыг 2007 оны 10 дугаар сарын 1-5-ны өдрүүдэд □□□□□□ □□□□□□лаа.

2.2. Төрийн захиргаа, хүний нөөцийн удирдлагын манлайллыг хангах чиглэлээр:

Яамны 2006 оны 10 дугаар сарын үйл ажиллагааны мэдээллийг нэгтгэн боловсруулж, Засгийн газрын

Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн.

2006 оны 11 дүгээр сард Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх асуудлын жагсаалтыг гаргаж,

Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлэв.

Батлан хамгаалахын сайдын зөвлөлийн хуралдааныг зохион байгуулан 7 асуудлыг хэлэлцэн

шийдвэрлэв.

Төрийн албаны салбар зөвлөлийн хуралдааныг 2 удаа зохион байгуулж, 3 асуудлыг хэлэлцэн шийдвэрлэсэн.

Хууль тогтоомж, Сайд, Төрийн нарийн бичгийн даргын тушаалын хяналтанд авсан заалтуудын хэрэгжилтийг бүтцийн нэгж тус бүрээр гаргаж, холбогдох албан тушаалтанд танилцууллаа.

Энэ сард яаманд 224 албан бичиг ирснээс хугацаатай 18 албан бичиг байна. 38 хадгаламжийн нэгжийг 10 хүнд судлуулсан. 15 хүнд 34 хадгаламжийн нэгжээс 2150 хуудас материал шүүн үзэж архивын лавлагаа гаргаж ажиллалаа.

Яамны албан хаагчидтай "Пүрэв гараг-Мэдээллийн цаг" арга хэмжээг 4 удаа зохион байгуулан цаг үеийн асуудлаар мэдээлэл хийж удирдлагын баримт бичиг танилцуулан яамны офицер, ахлагч нартай Монгол Улсын Цэргийн тангараг давтах арга хэмжээг зохион байгуулав.

Батлан хамгаалах яамны үйл ажиллагааны талаар төвийн хэвлэл, мэдээллийн байгууллагад 7 хоногт, Засгийн газрын Хэвлэл мэдээллийн албанд шуурхай цаг тухайд нь мэдээлэл өгч ажилласан.

Иргэдийн өргөдөл, гомдлыг хүлээн авч шийдвэрлэх ажиллагааг журмын дагуу зохион байгуулж, 26 өргөдөл гомдол хүлээн авч, 90.7 / хувь/-ийг шийдвэрлэж хариу өгсөн байна.

Иргэдийг хүлээн авах байраар 10 гаруй хүн хүлээн авч, албан ёсны бүртгэлд авч тавьсан санал, хүсэлтийг барагдуулах арга хэмжээг авлаа.

2007 оны 10 дугаар сарын 19-ны 08.00-18.00 цагийн хооронд Батлан хамгаалах яам нээлттэй хаалганы мэдээллийн өдөрлөгөө зохион байгууллаа.

Өдөрлөгийн арга хэмжээг нээж Батлан хамгаалахын дэд сайд Б.Эрдэнэбат үг хэллээ.

Нээлттэй хаалганы өдөрлөгөөр Батлан хамгаалах яам, түүний харьяа байгууллага, аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааг иргэдэд сурталчлах, танилцуулах зорилгоор зурагт үзүүлэн самбар, танилцуулга материал тараан үзүүлэв.

Иргэд Батлан хамгаалах яамтай танилцаж Батлан хамгаалахын сайдын зөвлөлийн хуралдааны, уулзалтын, хүндэтгэлийн танхимууд, "Хар сүлд"-ний өргөөг үзэж сонирхлоо.

Энэ өдөр иргэдийн санал хүсэлтийг санал асуулгын хуудас болон амаар авч, архивын лавлагааг үнэ төлбөргүй гарган үйлчилгээ үзүүлэв.

Нээлттэй хаалганы арга хэмжээг нийт 2400 гаруй цэргийн албан хаагч, ард иргэд, ахмад болон залуу үеийн төлөөлөгчид үзэж сонирхлоо.

2.3. Бодлогын хэрэгжилтийг зохицуулах чиглэлээр:

“Монгол Улсын зарим нутаг дэвсгэрт тэсэрч, дэлбэрэх зүйлийг хайн илрүүлж, аюулгүй болгох тухай” асуудлыг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн.

Батлан хамгаалах болон аюулгүй байдлыг хангах зориулалт бүхий тусгай хэрэгцээний газрыг баталгаажуулах асуудлыг Батлан хамгаалахын сайдын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэхээр бэлтгэж байна.

“Зарим төрлийн, барилга байгууламжийг акталж, данснаас хасах тухай” Батлан хамгаалахын сайдын 2007 оны н/03 дугаар тушаалын хэрэгжилтийг зохион байгуулан ажиллаж байна.

Яамны харъяа агентлаг, байгууллага, газар, хэлтсүүдээс барилга байгууламжид хийлгэх засварын ажлуудыг нэгтгэж, улсын төсвийн хөрөнгө оруулалтын 2008 оны төлөвлөгөөний төслийг сангийн яаманд хүргүүлсэн.

Яамны харъяа агентлаг, байгууллага, газар, хэлтсүүдээс барилга байгууламжид хийлгэх засварын ажлуудыг нэгтгэж, улсын төсвийн хөрөнгө оруулалтын 2008 оны төлөвлөгөөний төслийг Сангийн яаманд хүргүүлсэн.

2007 оны Улсын төсвийн хөрөнгө оруулалтын нэмэлт тодотголоор хувиарлагдсан 861.9 сая төгрөгийн их засвар, тоног төхөөрөмж нийлүүлэх ажлыг эхлүүлээд байна.

НҮБ-ийн энхийг сахиулах болон олон улсын бусад ажиллагаанд оролцогч цэргийн албан хаагчдад зориулсан 50 айлын орон сууц барихад технологийн хяналт тавин 5-р давхарын угсралтын ажил хийгдэж байна.

Агентлаг, харьяа төсөвт байгууллагуудын 2007 оны 9-р сарын төсвийн гүйцэтгэлийн болон авлага, өглөгийн мэдээг шалган хүлээн авч нэгтгэж холбогдох албан тушаалтанд танилцуулсан.

Батлан хамгаалах салбарын харьяа төсөвт байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагааг программжуулах стандарт төслийн хэрэгжилтийг сайжруулах ажлын хүрээнд Монгол цэргийн музей, Батлан хамгаалахын архив, Батлан хамгаалахын эмгэг судлал, шүүх эмнэлгийн санхүүгийн үйл ажиллагаатай танилцлаа.

Батлан хамгаалах салбарын харьяа төсөвт болон аж ахуйн нэгж байгууллагуудын 2007 оны 3-р улирлын санхүүгийн тайланг нэгтгэн хүлээн авч байна.

2.4. Мэдээлэл, хяналт-шинжилгээ, үнэлгээний чиглэлээр

Батлан хамгаалах яамны харьяа “Монгол цэрэг жуулчин”, “Транс-сэргэлт” ТӨҮГ-уудын санхүүгийн үйл ажиллагаанд хяналт–шинжилгээ хийж, үнэлгээ дүгнэлт өгч ажилласан.

Батлан хамгаалах яамны харьяа “Дуулга” теле студийн нэвтрүүлэг, Зэвсэгт хүчний “Соёмбо” сонины нийтлэлийн бодлого, редакцийн үйл ажиллагаанд хяналт–шинжилгээ хийж, үнэлгээ өглөө.

Яамны WEB хуудсыг цаг үеэ олсон бодит мэдээллээр байнга баяжуулан байгууллагын нээлттэй байдлыг хангахад мэргэжлийн болон, техникийн дэмжлэг үзүүлэн ажиллаж байна.

Гурав. Бэлэн байдал, байлдааны бэлтгэл сургалтын талаар:

ЗХЖШ-ын даргын баталсан удирдамжийн дагуу Зэвсэгт хүчний 011, 027, 065, 089, 310, 326, 330 дугаар ангиудын байлдааны болон тусгай үүрэг гүйцэтгэх бэлэн байдлыг “Зэвсэгт хүчний анги, салбаруудын байлдааны болон тусгай үүрэг гүйцэтгэх бэлтгэлжилтийн түвшинг шалгаж үнэлэх заавар”-ын дагуу шалгаж, илэрсэн дутагдлыг газар дээр нь засуулж, дүнг нотломжоор гарган цаашид авах арга хэмжээг тодорхойллоо.

“Ерөнхий зориулалтын цэргийн мотобуудлагын анги, салбаруудын тайван цагийн орон тоог олон талт үүрэг гүйцэтгэхэд нийцүүлэн өөрчлөх” саналыг боловсруулсны гадна “ЗХЖШ-аас Зэвсэгт хүчний анги, байгууллагад зохион байгуулж явуулах хяналт шалгалтын тогтолцоо”-г боловсронгуй болгох санал боловсруулж, ЗХЖШ-ын даргын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлээ.

Зэвсэгт хүчний анги, байгууллагын жижүүрүүдэд зарлан мэдээллийн дадлагын дохиог 2 удаа өгч зарлан мэдээллийн сувгийн бэлэн байдлыг шалгаж, холбогдох арга хэмжээг авч үүрэгжүүллээ.

Байлдааны жижүүрлэлтийн анги, салбаруудын хүч хэрэгслээр энэ сард 6023 агаарын хөлгийн нислэгт радиолокацийн станцын болон диспетчерийн хяналт тавьснаас 5526 нь олон улсын, 491 нь орон нутгийн, 6 нь тусгай үүргийн нислэг байв. Нислэгийн горим, маршрутын зөрчил илрээгүй.

“Улсын нисэхийн нислэг үйлдэх заавар”, “Улсын нисэхийн инженерийн албаны заавар”, “Нисэгч, инженер техникч нарыг гэрчилгээжүүлэх заавар” зэрэг удирдлагын баримт бичгүүдийг боловсруулж, батлуулахад бэлэн болголоо.

Зэвсэгт хүчний удирдах бүрэлдэхүүний заах аргын цугларалтыг “Зэвсэгт хүчний байгуулалтыг 2015 он хүртэл хөгжүүлэх хөтөлбөр ба цэргийн сургалт бэлтгэл” сэдвээр бэлтгэж, 10 дүгээр сарын 7-11-ний өдрүүдэд зохион байгуулан явууллаа.

Цугларалтанд цэргийн сургалт бэлтгэлийг гардан хариуцдаг захирагчийн орлогч нарыг хамруулан оролцуулснаараа онцлогтой бөгөөд сургалтын арга зүй, сургалтын орчин, төлөвлөлтийг боловсронгуй болгох аргачлалын талаар нилээдгүй мэдээллийг сонсож, харилцан санал бодлоо хуваалцан ярилцаж, мэдлэгийнхээ хүрээг тэлснээс гадна анги, байгууллагынхаа цэргийн сургалт бэлтгэлийг зохион байгуулах талаар шинэ санаа авч, энэ талаарх ойлголтын

түвшингээ нэмэгдүүлж, тодорхой шийдэлд хүрсэнд цугларалтын ач холбогдол оршиж байна.

Зэвсэгт хүчний удирдах бүрэлдэхүүний заах аргын цугларалтын төгсгөлд ангиудын захирагч, захирагчийн орлогч нартай 2007 оны гуравдугаар улирлын сахилгын дүнг гаргаж, ЗХЖШ-ын дарга тодорхой үүрэг даалгавар өглөө.

Мөн Зэвсэгт хүчний удирдах бүрэлдэхүүний заах аргын цугларалтанд оролцсон ЗХЖШ-ын газар, хэлтсийн дарга нар, анги, байгууллагын захирагч нар болон ЗХЖШ, ЦТГ, ХШҮГ, ҮААХ-ийн бүрэлдэхүүнтэй 2006-2007 оны сургуулийн жилийн II үеийн төгсгөлийн “ЗХЖШ-ын даргын нэрэмжит шалгалт”-ыг зохион байгуулж явууллаа. ЗХЖШ-ын бие бүрэлдэхүүний сурлагын ерөнхий амжилт, чанар өмнөх жилийнхтэй харьцуулбал 1,4 хувиар тус тус өсч, “Үүрэг биелүүлэх боломжтой” үнэлэлттэй шалгагдлаа.

2006-2007 оны сургуулийн жилийн II үеийн төгсгөлийн “ЗХЖШ-ын даргын нэрэмжит шалгалт”-ыг Зэвсэгт хүчний 011, 027, 065, 089, 330, 326 дугаар ангиудад, төгсөлтийн шалгалтыг бусад ангиудад явуулж, дүнг нэгтгэж байна.

“Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүний ёс суртахуун, сэтгэл зүйн тогтвортой байдлыг хангах ажлыг шалгаж үнэлэх заавар”-ыг боловсруулан ЗХЖШ-ын даргаар батлуулан анги, байгууллагуудад хүргүүлсний гадна Ерөнхий боловсролын дунд сургуулийн ахлах ангийн сурагчдад эх оронч үзэл, цэргийн хөдөлмөрийн онцлогийг сурталчлах зорилготой “Эр зоригийн сургууль”-ийг 8 сургуулийн 160 хүүхдийг хамруулан БХИС, 119 дүгээр ангид зохион байгуулан явуулж, хэвлэл, мэдээллийн хэрэгслэлээр сурталчиллаа.

Зэвсэгт хүчний шинэчлэлийн бодлого, хилийн чанадад үүрэг гүйцэтгэж буй цэргийн албан хаагчдын ажиллагааг олон нийтийн мэдээллийн хэрэгслэлээр сурталчлах ажлыг “Соёмбо”, “Зууны мэдээ” сонинтой хамтран зохион байгуулж, Монголын радиотай хамтран “Дайчидтай ярилцах цаг” нэвтрүүлгийг 2 удаа бэлтгэн явууллаа.

ЗХЖШ улс орныг цэргийн хүчээр батлан хамгаалах зорилго бүхий төрийн цэргийн байгууллагуудыг цэргийн мэргэжлийн нэгдмэл удирдлагаар хангах дээд байгууллага болж, бие даасан үйл ажиллагаагаа явуулж эхэлсний 10 жилийн ойн баярыг тэмдэглэн өнгөрүүлэв.

ЗХЖШ-ын бүтцийн нэгжүүд түүхт ойгоо угтаж оны эхнээс эхлэн 1-2 бүтээлч ажил хийх хөдөлгөөн өрнүүлэн ажиллаж, шинэлэг, үр дүнтэй ажлуудыг санаачлан хийсний дотроос ЦТГ-ын “Мэдээлэл, дүн шинжилгээ, сургалтын танхим”, “Зэвсэгт хүчний мэдээллийн төв”, АТГ-ын “Хааны эрэлд-2007” олон улсын хээрийн сургуулийн бэлтгэлийг хангах ажлын хүрээнд Зэвсэгт хүчний энхийг сахиулах ажиллагааны олон улсын төвд байгуулсан “240 хүний суудалтай лекцийн заал”, “24 хүний

халуун ус”, “Интернетийн үйлчилгээний танхим”, “256 дугаар ангийг үлгэр жишээ тохижуулан жишиг хотхон болгосон ажлууд Зэвсэгт хүчний хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулсан бүтээлч ажил болсны гадна ЦУДСТГ-аас гаргасан “Мэргэн буудагчийн гарын авлага”, “Танк эсэргүүцэгч гар винтовын сайжруулалт” туршилт, Сургалтын бодлогын хэлтсийн “Цахим сургалтын материалууд”, АТГ-ын боловсруулсан “Ар талын албадын дарга нарын гарын авлага” зэрэг бүтээлүүд оюуны хөдөлмөр шингэсэн шилдэг бүтээлч ажлуудаар шалгарлаа.

Иракийн эрх чөлөө” олон улсын цэргийн ажиллагаанд оролцож буй цэргийн багийн YIII ээлжийн бүрэлдэхүүн Олон үндэстний дивиз /төв-өмнөд/-ийн штаб байрлах Ад Дивинях хот дахь “Эко” баазын аюулгүй байдлыг хангах, хамгаалалтын үүргээ амжилттай биелүүлж байна.

Сиерра Леон Улсад зохион байгуулж байгаа НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд оролцож буй IY ээлжийн цэргийн багийн бүрэлдэхүүн болон Баруун Сахар, Конго, Судан, Этиоп, Эритри, Гүржид НҮБ-ын явуулж буй энхийг сахиулах ажиллагаанд Зэвсэгт хүчний 8 офицер цэргийн ажиглагчийн үүргээ хэвийн гүйцэтгэж байна.

“Афганистаны үндэсний армийг хөгжүүлэх хөтөлбөр”-т оролцож байгаа сургалтын хөдөлгөөнт багийн YII ээлжийн бүрэлдэхүүн Афганистаны үндэсний армийн 209 дүгээр корпусын 1 дүгээр бригадын артиллерийн салбаруудтай байлдааны сургуулийн буудлагыг амжилттай явууллаа. Сургалтын хөдөлгөөнт багийн YIII ээлжийн бүрэлдэхүүнтэй ажиллагааны өмнөх сургалтыг зохион байгуулж, бэлтгэлийг нь хангуулан Афганистанд илгээхэд бэлэн болголоо.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1999 оны 153 дугаар зарлигаар батлагдсан “Цэргийн анги, байгууллагыг аж ахуйн ажилд оролцуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 5 дахь заалт, ЗХЖШ, анги, байгууллагуудтай аж ахуйн нэгжүүдийн байгуулсан хамтран ажиллах гэрээний дагуу Зэвсэгт хүчний 014, 032, 167 дугаар ангиудаас ногоо хураах болон аж ахуйн ажилд 80 хугацаат цэргийн албан хаагч оролцлоо.

Зэвсэгт хүчний ангиудад батлагдсан төлөвлөгөө, хуваарийн дагуу ар талын бүх төрлийн хангалтыг зохион байгуулж явууллаа.

Улаанбаатар цэргийн хүрээний анги, салбаруудад А-80 автобензин 43,5 тн, дизелийн түлш 19,1 тн, А-93 автобензин 9,4 тн, тосолгооны материал, тусгай шингэн 1682 кг, хөдөөгийн анги, салбаруудад 55,3 сая төгрөгийг төсвийн санхүүжилтээр хуваарилан олгож, шатахууны хангалтыг зохион байгуулав.

Зэвсэгт хүчний 256 дугаар ангийн шатахууны нөөцөд хадгалагдаж байсан 105,4 тн А-80 автобензин, 512,4 тн дизелийн түлшийг сольж шинэчилсэн.

Зэвсэгт хүчний 120 дугаар ангийн гал тогооны тоног төхөөрөмжийг засварласны гадна 2007 оны мал мах бэлтгэх их нядалгааг эхлүүлж, 50,2 тн махыг Зэвсэгт хүчний 310 дугаар ангийн Налайх дахь хөргүүртэй зооринд хийгээд байна.

“Авто, хуягт танкийн техникийн ашиглалтын /хадгалалт/ заавар”-ыг шинэчлэн боловсруулах ажлыг үргэлжлүүлж, Зэвсэгт хүчний анги, байгууллагуудын авто, хуягт танкийн техникийг өвлийн улирлын ашиглалтад шилжүүлэн улирлын техникийн үйлчилгээний явцад хяналт тавьж, мэргэжлийн дэмжлэг үзүүлэв.

“Дизель-БТР”, “Техникийн оношлогоо, үйлчилгээ, засварын төв” төслүүдийг боловсруулан ЗХЖШ-ын даргын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлж, шийдвэрлүүлэв.

Зэвсэгт хүчний анги, салбаруудын 10 дугаар сарын цахилгаан, дулаан, цэвэр, бохир усны төлбөрийн бичилтэд хяналт тавьж, Улаанбаатар хот, хот орчмын ангиудын хэрэгцээт нүүрсийг төлөвлөрсөн журмаар Шивээ-Овоо, Багануурын уурхайгаас татан авч хангах ажлыг зохион байгууллаа.

Энэ оны төсвийн тодотголоор нэмж батлагдсан 582,0 сая төгрөгөөр 15 анги, салбарын 22 барилга, байгууламжид нэмж засварын ажил хийхээс Зэвсэгт хүчний 014, 015, 016, 119, 326 дугаар ангиудын халуун усны барилгыг засварлаж, цахилгаан халаагуур, тоноглол солих ажлууд 40-90 хувийн, 032 дугаар ангийн цэргийн байрны бэхэлгээ, засварын ажлын гүйцэтгэл 70 хувийн, сахилгын байрны засварын ажлын гүйцэтгэл 50 хувийн, халуун усны барилгын засвар 80 хувийн, гэрээт цэргийн байрны барилгын засвар 80 хувийн, 326 дугаар ангийн чийрэгжүүлэлтийн төвийн барилга угсралтын ажил 10 хувийн, 120 дугаар ангийн гал зуухны барилгын дээврийн засварын ажил 50 хувийн, 167 дугаар ангийн ар талын штабын барилгыг 10 айлын орон сууц болгон засварлах ажил 50 хувийн, 065 дугаар ангийн 278 дугаар салбарын штабын байрны засварын ажил 50 хувийн, зэвсгийн агуулахын хашаа сэргээх, харуулын цамхаг барих ажил 10 хувийн, 314 дүгээр ангийн спорт заал, гараажийн бэхэлгээ засварын ажил 70 хувийн хэрэгжилттэй байна.

Зэвсэгт хүчний Улаанбаатар цэргийн хүрээний 3 ангид 96 нэрийн 4235850 төгрөгийн эм, эмнэлгийн хэрэглэл, аппарат, багаж, ороох боох материалын нөхөн хангалт хийж, Дархан-Уул аймгийн Хонгор суманд эмч нарын болон ариутгал, цэвэрлэгээний баг томилон ажиллуулж, цианит натрийн хордлого авсан хүмүүст эмнэлгийн нарийн мэргэжлийн тусламж үйлчилгээ үзүүлэв.

Дүгнэлт

Батлан хамгаалах салбарын үйл ажиллагаа, Зэвсэгт хүчний хэмжээнд цэргийн сургалт, өдөр тутмын үйл ажиллагаа хэвийн зохих түвшинд байж төр засгаас өгөгдсөн байлдааны болон тусгай үүргийг биелүүлэхэд бэлэн байна.

Хууль зүйн чиглэлээр:

УИХ-ын гишүүн Д.Дондог, Ч.Раднаа нарын санаачилсан Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, УИХ-ын гишүүн Л.Гүндалайгийн санаачилсан Ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Ерөнхийлөгч Н.Энхбаярын санаачилсан Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн төслүүдэд Засгийн газраас өгөх санал дүгнэлтийн төсөл, Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх Палермогийн конвенц болон түүний нэмэлт протоколуудад Монгол Улс нэгдэн орох тухай хуулийн төслийг боловсруулан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэв.

Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Агаарын төлбөрийн тухай, Онцгой албан татварын тухай хууль, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль болон Улс төрийн албан тушаалтнуудын албан ажлын онцгой нөхцөлийн нэмэгдлийн хэмжээг шинэчлэн тогтоох, нөхөн олговрын доод хэмжээг шинэчлэн тогтоох болон төрийн албан хаагчдын ангилал, зэрэглэл, цалинг шинэчлэн тогтоох тухай УИХ-ын тогтоолын төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх зөвшөөрөл олгов.

Газрын төлбөрийн тухай, Монгол Улсын 2007 оны төсвийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хууль болон Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх 2008 оны Үндсэн чиглэл батлах тухай, МУ-ын хилийн зурвас газрыг Улсын тусгай хэрэгцээнд авах тухай зэрэг УИХ-ын тогтоолын төслийн үзэл баримтлалыг Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх журмын тухай хуульд заасан журмын дагуу хянан шийдвэрлэв.

Хөрөнгийн үнэлгээ хийх үйл ажиллагааны тухай, Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Компанийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Геодези зураг зүйн хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд тус тус санал өгөв.

“Төрийн захиргааны, төрийн үйлчилгээний албан тушаалын ангилал, зэрэглэл, цалин хөлс болон нөхөн олговрын доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай”, “Нийгмийн даатгалын сангаас олгож байгаа тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх тухай”, “Үл хөдлөх хөрөнгийг худалдах болон балансаас балансад шилжүүлэх тухай”, “Төрийн өмчит хуулийн этгээд байгуулах тухай”, “Улсын нөөцийн эм, эмнэлгийн хэрэгслийн тухай”, “Барилгын салбарт авах зарим арга хэмжээний тухай”, “НҮБ-ын Онцгой байдалд үзүүлэх тусламжийн санд хандив өргөх тухай”, “Намрын чуулганаар хэлэлцүүлэх асуудлын тухай”, “Тогтоолд нэмэлт өөрчлөлт оруулах тухай”, “Жагсаалтад нэмэлт оруулах тухай” зэрэг Засгийн газрын нийт 32 шийдвэрийн төсөлд санал өгөв.

Монгол Улсын Засгийн Газар, Кувейт Улсын Засгийн Газар хооронд байгуулсан буцалтгүй тусламжийн хэлэлцээрт хууль зүйн дүгнэлт гарган хүргүүлсэн байна.

Хоёр. Удирдлага, зохицуулалтын мэдээлэл

Хууль зүй, дотоод хэргийн сайд Д.Одбаяр Азийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сангийн захирлуудын зөвлөлийн дарга Минори Шикитагийн урилгаар Япон Улсын Токио хотноо Азийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сангийн 25 жилийн ойн арга хэмжээнд оролцов.

Архивын салбарт хамтран ажиллах Монгол Улс, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хамтарсан комиссын 15 дугаар хуралдааныг 10 дугаар сарын 2-ны өдөр зохион байгууллаа.

Гадаад улсуудтай байгуулсан эрх зүйн туслалцааны гэрээний дагуу БНСУ, БНПУ, ОХУ-ын Хууль зүйн яамдаас ирүүлсэн шүүхийн 9 даалгаварт холбогдох ажиллагааг хийн эрх бүхий байгууллагад шилжүүлэв.

УИХ-ын 2004 оны 24 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын төрийн албаны шинэтгэлийн дунд хугацааны стратеги”-ийн зорилтын хүрээнд Монгол Улсын Засгийн газар, Дэлхийн банкнаас хамтран хэрэгжүүлж байгаа “Засаглалыг дэмжих төсөл”-ийн санхүүжилтээр хийгдэх Монгол Улсын төрийн албан хаагчийн тоо бүртгэлийг улсын хэмжээнд зохион байгуулах ажлын хүрээнд тус яам, харьяа агентлагийн төрийн албан хаагчдыг уг тооллого, бүртгэлд хамруулах ажлыг ХЗДХ-ийн сайдын

2007 оны 203 дугаар тушаалын дагуу томилогдсон салбар комисс, ажлын хэсгийн гишүүд, Төрийн албаны зөвлөлөөс томилогдсон тоологчдын хамт зохион байгууллаа. ХЗДХЯамны нийт албан хаагчид уг тооллогод хамрагдав.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2007 оны 97 дугаар зарлиг, Монгол Улсын Засгийн газрын 2007 оны 190 дүгээр тогтоолоор батлагдсан “Нээлттэй хаалганы өдөр”-ийг тэмдэглэн өнгөрүүлэх ажлыг ХЗДХ-ийн сайдын 2007 оны 195 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсгээс тус яам, харьяа агентлагийн хэмжээнд зохион байгуулж, тайланг ЗГХЭГ-т хүргүүлэв.

Тус яаманд хандаж иргэд, байгууллагаас ирүүлсэн 65 өргөдөл, гомдлыг хүлээн авч холбогдох ажиллагааг хийхийн зэрэгцээ 8 иргэний Төрийн нарийн бичгийн даргатай уулзах уулзалтыг зохион байгууллаа.

Иргэдийн эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор бэлтгэн явуулдаг “Хуулийн цаг”, “Асуувал хариулья” телевизийн нэвтрүүлэг, “Шинэ товчоо” радио нэвтрүүлгийн ээлжит дугаарыг бэлтгэн нэвтрүүлэв.

Сумдын Засаг даргын Тамгын газрын дарга бөгөөд нотариатчийн үүрэг гүйцэтгэгчдийн бүсчилсэн сургалтыг Баянхонгор, Дундговь аймгуудад зохион байгуулав.

Гурав. Бусад ажлын талаарх мэдээлэл

Тайлангийн хугацаанд Сайд, агентлагийн дарга, Засаг даргын нийт 15 тушаалыг хянаж, холбогдох арга хэмжээг авсан болно.

Хэвлэл мэдээллийн хэрэгсэл 8, үйлдвэрчний эвлэлийн байгууллага 4, төрийн бус байгууллага 47, шашны байгууллага 1-ийг улсын бүртгэлд бүртгэж гэрчилгээ олгон, 8 байгууллагын улсын бүртгэлд нэмэлт, өөрчлөлт оруулав.

Тайлангийн хугацаанд Эрх зүйн мэдээллийн цахим сангийн нэгдсэн системд нийтдээ бие даасан хууль 1, нэмэлт өөрчлөлт оруулсан хууль 27, Ерөнхийлөгчийн зарлиг 2, Улсын Их Хурлын тогтоол 4, Засгийн газрын тогтоол 29-ийг нэмж оруулсан ба өмнө орсон актуудын хяналтын ажлыг үргэжлүүлэн хийж байна.

Нийтээр дагаж мөрдөх 9 эрх зүйн актыг улсын бүртгэлд бүртгэв.

Тайлангийн хугацаанд холбогдох төрийн захиргааны байгууллагуудын зөвшөөрлийг үндэслэн Монгол Улсад албан хэргээр удаан хугацаагаар оршин суух зөвшөөрөл гадаадын иргэн 1499 хүнд олгож, 1180 хүний оршин суух зөвшөөрлийг сунгаж, нутаг буцсан 1083 хүнийг бүртгэлээс хассан байна.

Монгол Улсад түр хугацаагаар ирсэн гадаадын иргэн 2235 хүнийг бүртгэж, нутаг буцсан 2205 хүнийг бүртгэлээс хассан болно.

Дээрхи хугацаанд албан болон хувийн хэргээр түр буюу удаан хугацаагаар ирэх гадаадын иргэдэд холбогдох төрийн захиргааны байгууллага, иргэдийн хүсэлтийг үндэслэн “орох” 295, “орох-гарах” 367, “олон удаагийн” 101, нийт гадаадын 772 иргэнд визийн зөвшөөрөл өгсөн байна. Мөн “гарах-орох” 542, “гарах” 2601, олон удаагийн 588, нийт 3731 виз олгож, 407 визийн ангилал солин, 817 визийг сунгажээ.

Монгол Улсын иргэдээс хувийн журмаар гадаадын иргэдийг урих хүсэлтийг хянан үзэж 292 гадаадын иргэнд Монгол Улсад хувийн хэргээр зорчих урилга олгосон байна.

Гадаад орнуудаас урьсан иргэнээ зохих хугацаанд бүртгүүлээгүй, хууль бусаар хөдөлмөр эрхлүүлсэн, визийн хугацааг хэтрүүлсэн, нуун далдалсан зэрэг зөрчлийн улмаас 90 байгууллага, аж ахуйн нэгжид Захиргааны хариуцлагын тухай хуулийн дагуу 73 сая 200 мян.төгрөгийн торгуулийн арга хэмжээ авчээ.

Мөн Монгол Улсад оршин суух, дамжин өнгөрөх, бүртгэл, хөдөлмөр эрхлэх журам зөрчсөн болон визийн хугацаа хэтрүүлсэн зэрэг зөрчил гаргасан 38 орны 959 гадаадын иргэнд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу 117 сая 350 мян.төгрөгийн торгууль ногдуулсан болно.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газар